



ХҮРТЭЭМЖТЭЙ САНХҮҮ

Санхүүгийн зохицуулах хорооны товхимол

2021 · 04 сар | Дугаар 29

ГАРЧИГ

- 2–3 “Алсын хараа–2050” ба даатгалын салбар
- 3–5 Зохицуулалтын мэдээ
- 6–7 Даатгалын компаниуд нь хөрөнгийн зах зээл дэх мэргэжлийн хөрөнгө оруулагчдын нэг юм
- 7–8 Санхүүгийн зохицуулах хорооны сургалтын журам
- 8 Сэтгэл зүйд тулгуурласан зээлийн эрсдэлийн үнэлээ
- 9 Тогтвортой санхүүжилт
- 10–13 Монгол улсын санхүүгийн хүртээмжийг үнэлэх түүвэр судалгаа
- 14–17 Санхүүгийн боловсрол
- 18 ТУЗ–ийн 2021 онд анхаарах асуудлууд
- 19 Олон улсын зах зээлийн мэдээ
- 20 ОЛОН УЛСЫН ХӨРӨНГИЙН ЗАХ ЗЭЭЛИЙН ИНДЕКС

Хүртээмжтэй санхүү

Санхүүгийн зохицуулах хорооны товхимол

8 Засгийн газрын IV байр, Бага тойруу–3 Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот, Монгол Улс 15160

+976–51–264444

press@frc.mn

www.frc.mn

Санхүүгийн зохицуулах хороо

@FRC_of_Mongolia

Зах зээлийн судалгаа, хөгжлийн газар

ТОГТВОРТОЙ ХӨРӨНГИЙН БИРЖ

Зах зээлийн судалгаа, хөгжлийн газрын референт Н.Нарантуяа

Нэгдсэн Үндэстний Байгууллагаас 2015 онд Тогтвортой хөгжлийн 17 зорилгыг баталж улс орнууд ядуурлыг тэглэх, уур амьсгалын өөрчлөлт, байгаль орчны доройтлыг нөхөн сэргээх, тэгш байдлыг хангах, энх тайвныг цогцлооход нэгдсэн. Түүнчлэн мөн онд 196 орон Франц Улсын Парис хотноо уулзаж дэлхийн дулаарлыг цельсийн 2 градусаас бага түвшинд тогтоох уур амьсгалын өөрчлөлтийн эсрэг Парисын хэлэлцээрийг баталсан. Улс орон, эдийн засгийн салбар бүр тогтвортой хөгжлийн төлөө нэгдэн ажилласнаар 5 жил болсон байна. Санхүүгийн зах зээл нь уг хөгжилд тогтвортой, ногоон санхүүжилт, хөрөнгө оруулалтаар хувь нэмэр оруулдаг. Тухайлбал өмнөх дугааруудад ногоон бонд, тогтвортой санхүүжилтийн талаарх мэдээллийг та бүхэндээ хүргэсэн бол энэ удаагийн дугаарт тогтвортой хөрөнгийн

зах зээл буюу хөрөнгийн зах зээл хэрхэн тогтвортой хөгжилд хувь нэмрээ оруулж буйг хүргэхийг зорилго.

Олон улсын хэмжээнд хөрөнгийн биржүүдийг тогтвортой хөгжилд чиглүүлэхээр Тогтвортой хөрөнгийн зах зээлийн санаачилга, Олон улсын хөрөнгийн зах зээлийн холбоо хөрөнгийн биржүүдийг гишүүнчлэлээр элсүүлж байна. Олон улсын хөрөнгийн зах зээлийн холбоо ногоон, нийгмийн, тогтвортой гэсэн 3 төрлийн бондын зарчмыг гаргаж, зохицуулагчид, хөрөнгийн биржүүд тогтвортой, ногоон бондын зохицуулалтыг боловсруулахад тус зарчмуудыг удирдлага болгодог ба Олон улсын хөрөнгийн зах зээлийн холбооноос 2014 онд анх ногоон, нийгмийн, тогтвортой байдлын бондын зарчмууд боловсруулж, 2018 онд дахин шинэчилж байжээ.

ТОГТВОРТОЙ ХӨГЖЛИЙН ЗОРИЛГО



Үргэлжлэл 9-р нүүрт >>



ТАНЫ САНХҮҮГИЙН МЭДЛЭГТ

Зээл

Монгол: Зээл олгогчоос зээлдэгч /хүн эсвэл байгууллага/-тэй зээлийн гэрээ байгуулан тодорхой мөнгөн дүнг, тодорхой заасан хугацаанд, тодорхой хүүтэйгээр эргүүлэн төлөхөөр тохиролцсон эсвэл эргэн төлөлт хийх талаар мэдэгдэл авсан үедээ буцаан төлөх мөнгөн дүн.



Loan

English: A specified sum of money lend by a creditor or lender (e.g. a bank) to a person or entity and repayable at a predetermined due date or after notice of repayment is given.

Эх сурвалж:

Банк санхүүгийн тайлбар толь бичиг



БОДЛОГЫН НИЙТЛЭЛ

“АЛСЫН ХАРАА–2050” БА ДААТГАЛЫН САЛБАР

Даатгал нь иргэн, өрх гэр, төр, хувийн хэвшлийн эрсдэлийг бууруулан, учирч болзошгүй, гэнэтийн хохирлоос үүдэх санхүүгийн хүндрэлээс эдийн засаг, нийгмийг хамгаалдаг тогтолцоо билээ. Мөн даатгалын компаниуд нь хөрөнгийн зах зээлийн мэргэжлийн хөрөнгө оруулагчид болдог тул уг зах зээлийн хөгжил нь хуримтлал, нөөцийн үр ашигтай хуваарилалтыг нэмэгдүүлж, хөрөнгийн зах зээлийн хөгжлийг дэмждэг.

Ийнхүү нийгэм, эдийн засаг, санхүү салбарын эрсдэлийн удирдлага, тогтвортой хөгжлийн чухал бүрэлдэхүүн хэсэг болсон даатгалын салбарын ирэх 30 жилд хүрэх үр дүнг “Алсын хараа–2050” Монгол Улсын Урт хугацааны хөгжлийн бодлогын “Эдийн засаг – Ухаалаг санхүүгийн зах зээл хэсэг”-т Олон улсын санхүүгийн зах зээлтэй холбогдсон олон тулгуурт, хүртээмжтэй санхүүгийн системийг хөгжүүлэх үндсэн зорилгыг хэрэгжүүлэх хүрээнд 3 үе шатанд хуваан дараах байдлаар тодорхойлсон. Үүнд:

I үе шат (2021–2030): Даатгалын салбарын тогтвортой байдлыг хангах хууль, эрх зүйн орчин бүрдэж, салбарын хамрах хүрээг нэмэгдүүлсэн байна.

II үе шат (2031–2040): Даатгалын салбарын гүнзгийрэлтийн түвшин олон улсын жишигт хүрсэн байна.

III үе шат (2041–2050): Технологийн дэвшлийн тусламжтайгаар хэрэглэгч бүр өөрийн хэрэгцээнд тохирсон даатгалын бүтээгдэхүүнийг хэрэглэх боломжтой зах зээлийг бүрдүүлсэн байна.

Тус бодлогын баримт бичигт тусгагдсан дээрх үр дүнд хүрэх зорилгоор хэрэгжүүлбэл зохих арга хэмжээг багцлан дараах байдлаар ангилан үзэж болох юм. Үүнд:

1. Даатгалын зах зээлийн тогтвортой байдлыг хангах, системийн эрсдэлээс урьдчилан сэргийлэх

- Даатгалын зах зээлийн тогтвортой байдлыг хангах, системийн эрсдэлээс урьдчилан сэргийлэх тулгуур зарчмуудыг баримтална.
- Даатгалын зах зээлийн тогтвортой байдлыг хангах, системийн эрсдэлээс

урьдчилан сэргийлэх зорилгоор эрсдэлийн удирдлагын зохицуулалтын тогтолцоог сайжруулж төлбөрийн чадварын стандартыг бүрэн нэвтрүүлнэ.

- Даатгалын зах зээлийн эрсдэлийг урьдчилан сануулах системийг бүрэн нэвтрүүлнэ.

2. Урт хугацааны даатгалын эрх зүйн орчин, давхар даатгалын тогтолцоог боловсронгуй болгож, зах зээлийг өргөжүүлэх

- Гаднын хөрөнгө оруулалттай урт хугацааны даатгалын компаниудыг дэмжиж, өрсөлдөөнийг нэмэгдүүлнэ.
- Урт хугацааны даатгалын үйл ажиллагааны эрх зүйн орчинг сайжруулан, хүртээмжийг нэмэгдүүлнэ.
- Давхар даатгалын тогтолцоог боловсронгуй болгоно.

3. Дэвшилтэт техник технологид суурилсан цахим даатгалын үйл ажиллагааг хөгжүүлж, хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалах эрх зүйн орчинг сайжруулах

- Технологид суурилсан даатгалын шинэ бүтээгдэхүүн, үйлчилгээний эрх зүйн орчинг боловсронгуй болгон бодлогоор дэмжинэ.
- Даатгалын гэрээний стандартыг тогтоож, бүртгэлийн процессыг хялбаршуулах, кибер даатгалыг хөгжүүлнэ.
- Даатгуулагчдын кибер аюулгүй байдлыг хангах, хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалах эрх зүйн орчинг бүрдүүлнэ.
- Даатгалын үйл ажиллагааг бүрэн тоон системд шилжүүлэх, хувийн мэдээллийн түүхэнд суурилан хураамж тогтооно.
- Даатгалын зах зээлд ашиглагдах технологийн шийдлүүд нь дэлхийн хөгжингүй орнуудтай эн зэрэгцэнэ.

4. Даатгалын салбарын хөрөнгийн зах зээл дэх оролцоог нэмэгдүүлэх

- Дүрмийн сан, нөөц сангийн хөрөнгийн зах зээл дэх хөрөнгө оруулалтыг идэвхжүүлнэ.
- Тэтгэврийн сан, хувийн тэтгэврийн даатгалын хөрөнгөөр хөрөнгийн зах зээлд хөрөнгө оруулалт хийх орчинг бүрдүүлнэ.
- Даатгалын компаниудын хөрөнгийн зах зээлээс хөрөнгө босгох үйл ажиллагааг эрчимжүүлнэ.

Мөн “Алсын хараа-2050” урт хугацааны хөгжлийн бодлогын баримт бичигт тусгагдсан “Ухаалаг санхүүгийн зах зээл”-г бий болгох зорилго зорилтуудаас гадна бусад олон зорилго, зорилтуудад даатгалын салбар чухал үүрэгтэйгээр оролцохоор байна. Тухайлбал,

- “Үндэсний нэгдмэл үнэт зүйл – Үндэсний бахархал, эв нэгдэл” хэсэгт музейн үзмэр, эд өлгийн зүйл, урлагийн бүтээлийн даатгалыг хөгжүүлэх;
- “Хүний хөгжил – Эрүүл мэнд” хэсэгт Эрүүл

мэндийн чанар, хүртээмжтэй тогтолцооны шинэчлэлийн чиглэлээр хувийн эрүүл мэндийн даатгалын тогтолцоог шинэчлэн, боловсронгуй болгох;

- “Амьдралын чанар ба дундаж давхарга – Нийгмийн хамгаалал ба даатгалын тогтолцооны шинэчлэл, Дундаж давхаргыг дэмжсэн санхүүжилт” хэсгүүдэд хувийн тэтгэврийн даатгалыг тогтолцоог боловсронгуй болгох, дундаж давхаргыг дэмжсэн, бага дунд орлоготой иргэд, аж ахуйн нэгжийг эрсдэлээс хамгаалсан хүртээмжтэй даатгал, эрсдэлтэй нөхцөлд ажиллаж буй ажилтнуудад зориулсан ажил олгогчийн заавал даатгалын бүтээгдэхүүн үйлчилгээ болон хуримтлалыг дэмжин урт хугацааны даатгалын бүтээгдэхүүний хамрах хүрээг нэмэгдүүлэх;
- “Эдийн засаг – Өрсөлдөх чадвартай брэнд бүтээгдэхүүн” хэсэгт экспортыг дэмжих, экспортын чиглэлийн үйлдвэр эрхлэгчдэд зориулсан батлан даалт, даатгалыг нэвтрүүлэх чиглэлээр экспортын даатгалыг хөгжүүлэх;

- “Ногоон хөгжил – Нүүрстөрөгч багатай, бүтээмжтэй, хүртээмжтэй ногоон хөгжил” хэсэгт уур амьсгалын өөрчлөлтөөс үүдэлтэй эрсдэлийн даатгалын тогтолцоог судалж бүрдүүлэх, байгаль орчин, нийгэмд ээлтэй төсөл, үйл ажиллагааг санхүүжүүлэх үндэсний ногоон санхүүгийн тогтолцооны нэг хэсэг болох ногоон даатгалыг бий болгох;
- “Амар тайван, аюулгүй нийгэм – Хүн нийгмийн амар тайван байдал” хэсэгт гамшгийн аюул, өртөг, эмзэг байдлыг бууруулах, гамшгийн эрсдэлээс урьдчилан сэргийлэх, даатгалын тогтолцоог боловсронгуй болгох;
- “Бүс, орон нутгийн хөгжил – Тогтвортой хөдөө аж ахуй” хэсэгт хөдөө аж ахуйн үйлдвэрлэлд дасан зохицох, эрсдэлийг бууруулах чадавхыг бэхжүүлэх, хөдөө аж ахуйд даатгалын тогтолцоог боловсронгуй болгож, гэнэтийн эрсдэлээс учирч болох эдийн засгийн хохирол, эрсдэлийг бууруулах.



ЗОХИЦУУЛАЛТЫН МЭДЭЭ

ХААЛТАЙ ӨРИЙН БИЧГИЙГ БҮРТГЭХ, ХЯНАЛТ ТАВИХ ЖУРАМ БАТЛАГДЛАА

“Банк бус санхүүгийн байгууллага /ББСБ/-аас гаргах хаалттай өрийн бичгийг бүртгэх, түүнд хяналт тавих журам”-ыг Санхүүгийн зохицуулах хорооны ээлжит наймдугаар хуралдаан /2021.04.28/-аар хэлэлцэн баталсан.

Засгийн газрын 2021 оны 42 дугаар тогтоолоор баталсан “Эрүүл мэндээ хамгаалж, эдийн засгаа сэргээх 10.0 (арван) их наядын цогц төлөвлөгөө”-тэй холбогдуулж хөнгөлөлттэй зээлийн эх үүсвэрийг зориулалтын дагуу ашиглах, зарцуулалтад хяналт тавих, банк бус санхүүгийн салбарт өрийн бичиг авах зэргээр аливаа хэлбэрээр байршуулахаас сэргийлэх, төрийн байгууллагуудын мэдээллийн нэгдмэл байдлыг хангах зорилгоор дээрх журмыг СЗХ-ноос боловсруулаад ээлжит хуралдаанаараа ийнхүү баталсан.

Дээрх журам хэрэгжиж эхэлснээр “Ажлын байрыг дэмжих зээл”-ийн эх үүсвэр ББСБ-ын салбарт өрийн бичиг татах, бусад хэлбэрээр байршуулах зэргээр учирч болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлж, Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуульд заасан харилцагчийг таньж мэдэх үйл ажиллагааг сайжруулж, хөрөнгө оруулагч, харилцагчийн эрх ашгийг хамгаалах эрх зүйн зохицуулалт бий болж байна. Мөн нээлттэй болон хаалттай өрийн бичгийн зах зээлийг нэгдсэн удирдлагаар зохицуулах, төрийн байгууллагуудын мэдээллийн нэгдмэл байдлыг хангах, нэгдсэн мэдээллийн сан бүрдүүлж, хамтын ажиллагааг уялдуулан тэдгээрийг бүртгэлжүүлэх замаар өрийн бичиг эзэмшигчдийн мэдээллийг сайжруулах нөхцөл бүрдэнэ.

“САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ СУРГАЛТЫН ЖУРАМ” БАТЛАГДЛАА

СЗХ эрхлэх асуудлынхаа хүрээнд зохицуулалтын салбарууд болох үнэт цаас, даатгал болон бусад санхүүгийн байгууллагуудад ажиллах мэргэжлийн оролцогчдыг чадавхжуулах, мэргэшүүлэх олон төрлийн сургалтууд зохион байгуулж, санхүүгийн зарим ажлыг эрхлэх эрх олгодог бөгөөд сургалтаа төр, хувийн хэвшлийн хамтын ажиллагааны хүрээнд санхүүгийн салбарын мэргэжлийн холбоодтой хамтран зохион байгуулж ажилладаг.

Эдгээр сургалтын үйл ажиллагааг зохицуулах сургалтын журам боловсруулан мөрдүүлэхээр боллоо. Журмын гол зорилго нь сургалтын үйл ажиллагааг нэгдсэн бодлого, удирдлага, зохион байгуулалт, арга зүйгээр хангаж, сургалтын хэлбэр, бүтцийг стандартчилах, улмаар сургалтын үр дүнг сайжруулж, салбарын оролцогчдыг мэргэшүүлэх, мэргэжлийн ур чадварыг нь тогтмол дээшлүүлэх замаар СЗХ-ны стратегийн зорилтод хүрэхэд сургалтын үйл ажиллагааны оролцоог нэмэгдүүлэх юм. Түүнчлэн санхүүгийн зах зээлийн тогтвортой байдлыг хангах, хөрөнгө оруулагч, үйлчлүүлэгчдийн эрх ашгийг хамгаалах, санхүүгийн төрөл бүрийн эрсдэлээс урьдчилан сэргийлэх тогтолцоо бүрдүүлэх, санхүүгийн салбарын хөгжлийг дэмжихэд сургалтын үйл ажиллагаа чухал үүрэг гүйцэтгэнэ.

Энэ зорилтын хүрээнд СЗХ-ны Ажлын албаны бүтцэд сургалтын асуудал хариуцсан “Санхүүгийн боловсрол, сургалтын алба”-ыг шинээр байгуулан ажиллаж байна.

Журамд сургалттай холбоотой үүсэх бүхий л харилцааг зохицуулахаар тусгаснаас гадна сургалтын үйл ажиллагаанд оролцогчдын чиг үүргийг нарийвчлан тодорхойлж, сургалтын нэгдсэн мэдээллийн бааз үүсгэх, хөтлөх ажиллагааг ч мөн тусгалаа.

САНХҮҮГИЙН ЗОРИЛТОТ ХОРИГ АРГА ХЭМЖЭЭГ ХЭРЭГЖҮҮЛЭХ НЬ



Санхүүгийн зорилтот хориг арга хэмжээ гэж юу вэ?

Санхүүгийн зорилтот хориг арга хэмжээ нь үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэх, терроризмыг санхүүжүүлэх гэмт хэргийг үйлдэхээр зэхэж буй этгээдүүдийн мөнгөн хөрөнгийн шилжилт, хөдөлгөөний урсгалтай тэмцэхээр гаргасан Нэгдсэн Үндэстний Байгууллага /НҮБ/-ын Аюулгүйн зөвлөлийн тогтоолуудын нэг хэсэг юм.

НҮБ-аас тавьж буй аливаа хориг арга хэмжээ нь санхүүгийн зорилтод хориг арга хэмжээнээс гадна үйл ажиллагаанд суурилсан санхүүгийн хориг, эдийн засаг, тодорхой нэг салбарын хориг арга хэмжээ болон холбогдох санхүүгийн хориг, сонор сэрэмжийг нэмэгдүүлэх арга хэмжээг багтаана. НҮБ-ын гишүүн улсын хувьд Монгол Улс нь НҮБ-ын Аюулгүйн Зөвлөлийн тогтоол, түүний дотор хориг арга хэмжээ авахтай холбоотой тогтоолыг дагаж мөрдөх үүрэгтэй.

Санхүүгийн зорилтот хориг арга хэмжээг хэрэгжүүлэх үүргээ биелүүлээгүй тохиолдолд хариуцлага хүлээх үү?

Хэрэв та үүргээ биелүүлээгүй тохиолдолд Зөрчлийн эсхүл Эрүүгийн хуульд заасан хариуцлага хүлээнэ. Зөрчлийн хуулийн 5 дугаар зүйлийн 5.10-т оногдуулах захиргааны хариуцлагын талаар заасан бөгөөд хүнийг хорин мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг хоёр зуун мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох заалттайг анхаарна уу.

ДҮРЭМ, ЖУРМЫН ЭМХТГЭЛ ГУРВАН БОТЬ ХЭВЛЭГДЭН ГАРЛАА

СЗХ-ноос эрхлэн гаргасан захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн санд бүртгэлтэй захиргааны хэм хэмжээний акт, дүрэм, журмын эмхтгэл гурван боть хэвлэгдэн гарлаа. Тодруулбал, Дэлхийн банкны төслийн санхүүжилтээр зохицуулалтын салбарын мэргэжлийн оролцогчид, мэргэжлийн холбоод, төрийн бус байгууллага, СЗХ-ны



нийт албан хаагчдын ажлын хэрэгцээнд зориулан

“Даатгалын салбарын захиргааны хэм хэмжээний актын эмхтгэл”

“Үнэт цаасны салбарын захиргааны хэм хэмжээний актын эмхтгэл”

“Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх, үл хөдлөх эд хөрөнгө зуучлал, үнэт эдлэлийн зохицуулалтын дүрэм, журмын эмхтгэл” –үүдийг эрхлэн гаргалаа.

Эдгээр эмхтгэлд даатгал, үнэт цаас, мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх, үл хөдлөх эд хөрөнгө зуучлал, үнэт эдлэлийн зохицуулалтын салбарын үйл ажиллагаа, эрх зүйн харилцааг зохицуулсан захиргааны хэм хэмжээний актын нэгдсэн санд бүртгэлтэй захиргааны хэм хэмжээний акт холбогдох дүрэм, журмууд бүрэн багтсан.

Иймд СЗХ-ны зохицуулалтын салбарын мэргэжлийн оролцогчид, мэргэжлийн холбоод, төрийн бус байгууллагууд танилцаж, үйл ажиллагаандаа ашиглахыг зөвлөж байна.

ХОРООНЫ 2020 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААГ ЭДИЙН ЗАСГИЙН БАЙНГЫН ХОРОО ХЭЛЭЛЦЭЖ ДҮГНЭЛЭЭ



Өнгөрсөн онд цар тахлаас шалтгаалж санхүүгийн зах зээлд эрсдэлтэй, амаргүй нөхцөл байдал тулгарсан ч УИХ-ын 2020 оны 32 дугаар тогтоолоор баталсан “Коронавируст халдвар /Ковид-19/-ын цар тахлын үед санхүү эдийн засгийн тогтвортой байдлыг хангах, эрсдэлээс урьдчилан сэргийлэх, төрийн үйлчилгээнд цахим шилжилт хийх”, 21 дүгээр тогтоолоор баталсан “Зээлийн хүүг бууруулах стратеги”-ийг хэрэгжүүлэх чиглэлээр СЗХ хэд хэдэн арга хэмжээг авч хэрэгжүүлсэн. Тухайлбал, хөрөнгийн зах зээлийг дэмжих зорилгоор хаалттай өрийн хэрэгслийг арилжаалах, нийтэд санал болгон гаргах үнэт цаасны шаардлага, шалгуурыг хангахад хүндрэлтэй байгаа жижиг, дунд үйлдвэрлэгч нарт биржийн бус зах зээлээс санхүүжилт босгох “Биржийн бус зах зээлийн үйл ажиллагааны журам”-ыг баталж, санхүүжилт босгох таатай нөхцөлийг бүрдүүлсэн. Түүнчлэн үнэт цаасны давхар бүртгэлийн систем буюу хоёр биржийн хооронд үнэт цаасыг чөлөөтэй хөрвүүлж, арилжаалах орчинг бүрдүүлснээр анх удаа зах зээлийн үнэлгээ 3.0 их наяд төгрөгт хүрсэн. Мөн энэ он гарснаар Монгол Улсад анх удаа олон нийтэд нээлттэй арилжаалах

хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны анхдагч зах зээлийн арилжааг эхлүүлэхийн зэрэгцээ Хөрөнгийн биржид давхар бүртгэлтэй “Эрдэнэ Ресурс Девелопмент Корпорэйшн” ХК (ERDN)-ийн тодорхой хувьцааг Канадын хөрөнгийн бирж рүү амжилттай хөрвүүлж хөрөнгийн зах зээлийн хөгжилд шинэ хуудас нээсэн үйл явдал болсон.

Цаашид ч хөрөнгө оруулагчдыг хөрөнгийн зах зээл рүү татахын тулд юуны түрүүнд хөрөнгө оруулалтын сангийн эрх зүйн орчныг сайжруулж хуулийн этгээдийн олон сонголтот хэлбэрийг бий болгох, түүнчлэн манай улсын хөрөнгийн зах зээлийг хөгжүүлэхэд томоохон нөлөө үзүүлж чадах зээлжих зэрэглэл өндөртэй олон улсын томоохон санхүүгийн байгууллагуудыг зах зээлд татан оролцуулж, хөрөнгө оруула хад дэмжлэг үзүүлэх чиглэлд ажиллана гэдгээ СЗХ-ны дарга Д.Баярсайхан танилцуулсан юм.

Тайлантай холбоотойгоор Байнгын хорооны дарга Ж.Ганбаатар, байнгын хорооны гишүүн Т.Доржханд, Д.Батлут, М.Оюунчимэг нар асуулт асууж, салбарын хууль, эрх зүйн өөрчлөлтийг цаашид гүнзгийрүүлэх, шаардлагатай хуулиудыг хугацаа алдалгүй батлан гаргах, хөрөнгийн зах зээл, даатгалын зах зээлийг хурдацтай хөгжүүлэх хөгжлийн оновчтой бодлого явуулах чиглэлийн хүрээнд СЗХ-ны удирдлагуудаас хариулт, тайлбар авч, санал бодлоо хэллээ.

НИЙТ ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН АНХААРЛАД

Компанийн тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.5-д заасны дагуу хувьцаат компанийн төлөөлөн удирдах зөвлөл нь санхүүгийн жил дууссанаас хойш 50 хоногийн дотор ногдол ашиг хуваарилах эсэх талаар хэлэлцэн шийдвэрлэж, энэ тухай СЗХ-нд мэдэгдэхээр зохицуулагдсан.

Хуулиар тогтоосон дээрх хугацаа 2021 оны 02 дугаар сарын 20-ны өдрөөр дуусгавар болсон. Мөн онд нэр бүхий 97 хувьцаат компани ногдол ашгийн талаарх мэдэгдлээ ирүүлснээс 33 хувьцаат компани нийт 101.2 тэрбум төгрөгийн ногдол ашиг тараахаар шийдвэрийг ирүүлээд байна.



БАЙР СУУРЬ

ДААТГАЛЫН КОМПАНИУД НЬ ХӨРӨНГИЙН ЗАХ ЗЭЭЛ ДЭХ МЭРГЭЖЛИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАГЧДЫН НЭГ ЮМ



Санхүүгийн зохицуулах хорооны 2021 оны 64 дүгээр тогтоолоор Даатгалын багц дүрмийн 2 дугаар хавсралт “Даатгагчийн төлбөрийн чадварын шалгуур үзүүлэлт, түүнд хяналт тавих журам”, 4 дүгээр хавсралт “Даатгалын нөөц санд болон албан журмын даатгалын санд төвлөрүүлэх хөрөнгийн хэмжээ, түүнийг хөрөнгө оруулалтад байршуулахад тавигдах нөхцөл, шаардлага”-уудад оруулсан нэмэлт өөрчлөлтүүд нь мөрдөгдөж эхлээд байна. Үүнтэй холбоотойгоор Санхүүгийн зохицуулах хорооны Даатгалын газрын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч З.Батболдоос зарим зүйлийг тодрууллаа.

Хөрөнгийн зах зээл дэх даатгалын салбарын оролцоо, өнөөгийн нөхцөл байдал ямар байна вэ?

Банк, даатгал, хөрөнгийн зах зээл нь санхүүгийн салбарын үндсэн 3 тулгуур салбар билээ. Дэлхий дахинд санхүүгийн салбар өндөр хөгжихийн хэрээр эдгээр салбаруудын харилцан хамаарал нэмэгдэж, зэрэгцэн хөгжих хэрэгцээ шаардлага зайлшгүй бий болсоор байна. Монгол Улсын хувьд сүүлийн жилүүдэд энэ хүрээнд гарч буй томоохон өөрчлөлтүүдээс дурдвал, Банкны тухай хуульд оруулсан нэмэлт өөрчлөлтийн дагуу системийн нөлөө бүхий банкууд нээлттэй хувьцаат компани байхаар хуульчлагдаад байгаа бол даатгалын салбарын хувьд 4 компани олон нийтэд хувьцаагаа нээлттэй арилжаалж байна.

Даатгалын компаниуд нь нөөцийн сан үүсгэн, тэрхүү нөөц сангаараа хөрөнгө оруулалт хийн, эдийн засаг, бизнес дэх дунд болон урт хугацааны санхүүжилтийн чухал бүрэлдэхүүн хэсгийг бий болгож байдаг, хөрөнгийн зах зээл дэх мэргэжлийн хөрөнгө оруулагчдын нэг. Энэ ч утгаараа олон улсад даатгалын салбарын нийт хөрөнгийн нэлээдгүй хувийг хөрөнгийн зах зээлд байршуулдаг. Тухайлбал, хөгжиж буй орнууд болох Аргентин, Малайз, Мексик зэрэг улсууд нь даатгалын салбарын нийт хөрөнгийн 50–аас 75 орчим хувийг, хөгжингүй орнууд болох Испани, Канад, Франц, Өмнөд Солонгос зэрэг улсууд нийт хөрөнгийн 40–өөс 75 орчим хувийг өрийн хэрэгсэл хэлбэрээр байршуулдаг бол бэлэн мөнгө, банкны харилцах, хадгаламж хэлбэрээр 10 хүрэхгүй хувийг байршуулж байна.

Манай улсын хувьд даатгалын компаниуд нийт хөрөнгийнхөө 50.5 хувь буюу 192.7 тэрбум төгрөгийг банкны харилцах, хадгаламжид, 4.0 хувь буюу 15.3 тэрбум төгрөгийг банкны хадгаламжийн сертификат хэлбэрээр, 4.4 хувь буюу 16.9 тэрбум төгрөгийг компанийн өрийн хэрэгсэл хэлбэрээр, 1.7 хувь буюу 6.6 тэрбум төгрөгийг хувьцаа хэлбэрээр тус тус байршуулж байна. Үүнээс дотоодын даатгалын компаниудын нийт хөрөнгө оруулалтын 83 хувь нь зөвхөн нэг л төрлийн хөрөнгөд байршсан гэдгийг харж болно. Цаашид даатгалын салбарын хөрөнгийн зах зээл дэх оролцоог нэмэгдүүлэх, эрсдэлийг тархаан байршуулж, хөрөнгө оруулалтын олон талт боломжуудыг бий болгох шинэлэг арга механизмыг дэмжих хүрээнд эрх зүйн зохицуулалтуудыг шинэчлэн сайжруулж, бодлогоор дэмжих

шаардлагатай байна.

Та хөрөнгө оруулалтын шинэлэг арга механизм гэж дурдлаа. Энэ талаар тодруулбал?

Олон улсад газар хөдлөлт, хар салхи гэх мэт байгалийн гамшгийн эрсдэлийг санхүүжүүлэх хөрөнгийн эх үүсвэр даатгалын салбарт дутагдалтай байдаг тул 1990–д оноос уламжлалт бус эрсдэлийг шилжүүлэх арга механизм /Alternative Risk Transfer/–г ашиглан, даатгалын эрсдэлийг шилжүүлэх, давхар даатгагчаас өөр субъект, эрсдэлийг үүрч, санхүүжүүлэх шинэ хөрөнгийн эх үүсвэрийг бий болгож эхэлсэн. Дэлхийн нийт даатгалын салбарын хөрөнгийн хэмжээ 587 тэрбум ам.долларт хүрсэн бөгөөд үүний 15.5 хувь буюу 91 тэрбум ам.долларын хөрөнгийг Catastrophe bonds, Sidecars, ILW, Collateralized Re зэрэг уламжлалт бус арга механизмуудыг ашиглан босгосон байна.

Эдгээр нь тусгай зориулалтын давхар даатгалын компани байгуулж, Даатгалын эрсдэлд суурилсан үнэт цаас /Insurance linked securities/ буюу бонд, үүсмэл санхүүгийн хэрэгсэл гаргах замаар хөрөнгийн зах зээлээс хөрөнгө босгон, даатгалын эрсдэлийг тархаан байршуулж, даатгалын компаниудын эрсдэл даах чадамжийг нэмэгдүүлэх арга хэрэгслүүд юм. Энгийнээр тайлбарлавал байгалийн гамшиг зэрэг бага давтамжтай ч их хэмжээний хохиролтой эрсдэлд зориулан хөрөнгийн зах зээлээс хөрөнгө босгох ба эрсдэл учраагүй тохиолдолд хөрөнгө оруулагч нь энгийн хөрөнгө оруулалтын өгөөжөөс гадна тухайн эрсдэлд зориулан төлсөн давхар даатгалын хураамжийг ашиг болгон авдаг ба энэхүү хөрөнгө оруулалтын орлого нь татвараас чөлөөлөгдсөн байдаг.

Манай улсын давхар даатгалын зах зээл гадны давхар даатгагчдаас ихээхэн хамааралтай байж, даатгалын хураамж хэлбэрээр багагүй хэмжээний валютын гадагш урсгалыг бий болгосоор байна. Энэхүү асуудлыг тодорхой хэмжээнд шийдвэрлэн хөрөнгийн зах зээлийн тусламжтайгаар дотоодын давхар даатгалын зах зээлийг хөгжүүлэх, түүнчлэн гадны хөрөнгө оруулагчдыг татах нэг арга зам нь энэхүү эрсдэл шилжүүлэх уламжлалт бус арга механизм байж болох юм.

Ерөнхийд нь дүгнэхэд, даатгалын болон хөрөнгийн зах зээл нь нягт

уялдаа холбоотойгоор хамтран ажиллаж, зэрэгцэн хөгжсөнөөр улс орны санхүүгийн зах зээлд томоохон эерэг өөрчлөлт, нөлөөллийг авч ирдэг гэж хэлж болно. Ийм ч учраас Монгол Улс олон тулгуурт санхүүгийн системийг цогцлоох, хөгжүүлэх талаар дунд болон урт хугацааны хөгжлийн бодлогын баримт бичгүүддээ тусган баталж, хэрэгжүүлж эхлээд байгаа билээ.

Бодлогын баримт бичгүүдийн хүрээнд СЗХ-ны зүгээс даатгалын салбараар дамжуулан хөрөнгийн зах зээлийг дэмжих чиглэлээр хийгдэж буй ажлуудаас онцлон дурдахгүй юу?

Даатгалын компаниуд нь даатгуулагч-иргэд, аж ахуйн нэгжид эрсдэл тохиолдсон үед тэдгээрийн санхүүгийн хамгаалалт болж, ирээдүйд учрах хохирлыг нөхөн төлөх үүрэг, хариуцлага хүлээж байдаг тул тэдгээрийн хөрөнгө оруулалтын үйл ажиллагаанд хууль журмын хүрээнд тодорхой хязгаарлалт, шаардлагуудыг тавьж өгсөн байдаг. СЗХ эдгээр шаардлага, хязгаарлалтууд тусгагдсан Даатгалын багц дүрмийн 2 дугаар хавсралт “Даатгагчийн төлбөрийн чадварын шалгуур үзүүлэлт, түүнд хяналт тавих журам”, 4 дүгээр хавсралт “Даатгалын нөөц санд болон албан журмын даатгалын санд төвлөрүүлэх хөрөнгийн хэмжээ, түүнийг хөрөнгө оруулалтад

байршуулахад тавигдах нөхцөл, шаардлага”-уудад олон улсын жишгийн дагуу даатгалын эрсдэлийг тархаан байршуулах, хөрөнгийн зах зээлийг дэмжих зорилгоор нэмэлт, өөрчлөлтүүдийг оруулсан.

Уг нэмэлт өөрчлөлтөөр даатгалын компанийн нийт хөрөнгө, нөөц сангаас банкны харилцах, хадгаламжид байршуулах дээд хувийг 10 хувиар бууруулан, өрийн хэрэгсэл болон Монголын хөрөнгийн биржийн нэгдүгээр ангиллын хувьцаа хэлбэрээр байршуулах хөрөнгийн дээд хэмжээг 10 хувиар нэмэгдүүлсэн. Үүнийг 2020 оны салбарын жилийн эцсийн санхүүгийн тайланд үндэслэн тооцвол, даатгалын нийт хөрөнгөөс компанийн өрийн хэрэгсэл болон хувьцаа хэлбэрээр хөрөнгө оруулалтад тус тус 114.6, 76.4 тэрбум төгрөг хүртэл байршуулах боломжтой болж байгаа юм.

Энэхүү зохицуулалтын өөрчлөлт, шинэчлэл нь даатгалын компаниудын хөрөнгө оруулалтын удирдлагыг зөв зохистой, оновчтой хэлбэрээр хэрэгжүүлж, дэлхийн хөгжлийн чиг хандлагатай хөл нийлүүлэн, даатгалын салбарын хөрөнгийн зах зээл дэх оролцоо, улмаар улс орны эдийн засагт эзлэх байр суурийг нэмэгдүүлэх, хөрөнгийн зах зээлийг хөгжүүлж зээлийн хүүг бууруулахад чухал ач холбогдолтой бодлого зохицуулалтын ажлын нэг хэсэг юм.

ТАЙЛБАР БА ЗӨВЛӨМЖ

САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ СУРГАЛТЫН ЖУРАМ

1. ЗОХИЦУУЛАХ ХАРИЛЦАА

Санхүүгийн зохицуулах хорооны даргын 2021 оны 4 дүгээр сарын 01-ний өдрийн 91 дүгээр тушаалаар баталсан “Санхүүгийн зохицуулах хорооны сургалтын журам”-аар СЗХ-ны зохицуулалтын салбарын оролцогчдод зориулсан эрх олгох, мэргэшүүлэх, захиалгат болон бусад сургалт зохион байгуулах, СЗХ, сургалт зохион байгуулагчтай сургалт зохион байгуулах гэрээ байгуулах, сургалтаар зохицуулалтын салбарт ажиллах эрх олгоход шаардах нөхцөл шаардлагыг хангах, салбарын оролцогчдыг мэргэшүүлэх, мэдлэгийг дээшлүүлэх, сургалтын үйл ажиллагаанд хяналт тавихтай холбогдон үүссэн харилцааг зохицуулсан.

2. СУРГАЛТЫН ЧИГЛЭЛ

СЗХ зохицуулалттай салбарын мэргэжлийн холбоотой хамтран, эсхүл дангаар дараах чиглэлээр сургалтуудыг зохион байгуулна. Үүнд:



3. СУРГАЛТЫН ТӨРӨЛ



4. СУРГАЛТЫН УДИРДЛАГА, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ

СЗХ нь зохицуулалттай салбарын оролцогчдод зориулсан сургалтын бодлогыг тодорхойлох, сургалтыг явуулах аргачлалыг олон улсын жишигт нийцүүлэн боловсруулах, баталж мөрдүүлэх, сургалтын хөтөлбөр, сургалттай холбоотой цахим мэдээллийн санг үүсгэх, хөтлөх, тэдгээрийн хадгалалт, хамгаалалтын найдвартай байдлыг хангаж ажиллах, сургалтын үйл ажиллагааг боловсронгуй болгох, бодлогын шийдвэр гаргахад шаардлагатай мэдээллээр хангах эрхтэй байхаар тус журамд зохицуулсан.

5. СУРГАЛТ ЗОХИОН БАЙГУУЛАХАД ТАВИГДАХ ШААРДЛАГА

Сургалт зохион байгуулагч нь сургалтын хөтөлбөрийн төслийг боловсруулж, тухайн сэдвийн хүрээнд сургалтын агуулга, хэрэгцээ шаардлагыг тодорхойлж СЗХ-ны Ажлын албанд хүргүүлэх, сургалтын зарыг өөрийн цахим хуудсаар олон нийтэд мэдээлж, сургалтад хамрагдах хүсэлтээ ирүүлсэн оролцогчийн бүртгэлийг хөтлөх, сургалтын танхим, техник хэрэгсэл, хэвлэх, хувилах тоног

төхөөрөмж бүхий сургалтын орчин бүрдүүлсэн байх, батлагдсан орон тоо бүхий сургалтын нэгж эсхүл сургалтын асуудал хариуцсан орон тооны ажилтантай байх, сургалтын хөтөлбөрийг хэрэгжүүлэх чадавх бүхий сургагч багштай байх зэрэг шаардлагуудыг тавьж тус журамд тодорхойлсон.

6. ҮР ДҮН

Сургалтын үйл ажиллагааг нэгдсэн бодлого, удирдлага, зохион байгуулалт, арга зүйгээр хангаж, сургалтын хэлбэр, бүтцийг стандартчилах, улмаар сургалтын үр дүнг сайжруулж, салбарын оролцогчдыг мэргэшүүлэх, мэргэжлийн ур чадварыг нь тогтмол дээшлүүлэх замаар СЗХ-ны стратегийн зорилтод хүрэхэд сургалтын үйл ажиллагааны оролцоог нэмэгдүүлэх боломжтой. Түүнчлэн санхүүгийн зах зээлийн тогтвортой байдлыг хангах, хөрөнгө оруулагч, үйлчлүүлэгчдийн эрх ашгийг хамгаалах, санхүүгийн төрөл бүрийн эрсдэлээс урьдчилан сэргийлэх тогтолцоо бүрдүүлэх, санхүүгийн салбарын хөгжлийг дэмжихэд чухал үүрэг гүйцэтгэнэ.

ФИНТЕК БА РЕГТЕК

СЭТГЭЛ ЗҮЙД ТУЛГУУРЛАСАН ЗЭЭЛИЙН ЭРСДЭЛИЙН ҮНЭЛГЭЭ

Psychometric credit scoring

Зээлийн эрсдэл үүсгэх хоёр хүчин зүйл байдаг нь зээлээ төлөх чадамж (санхүү) ба зээлээ төлөх хүсэл (сэтгэл зүй) юм. Өөрөөр хэлбэл, хүн зээл авсны дараа хугацаандаа зээлээ эргүүлэн төлөх эсэхэд нэг талаас тухайн хүний санхүүгийн нөхцөл байдал хамааралтай ч нөгөө талаас сэтгэл зүйн хүчин зүйлүүд хүчтэй нөлөө үзүүлдэг байна. Сэтгэл зүйн нөлөө нь зээлээ төлөх санхүүгийн чадамжтай хүнийг ч үр ашиггүй шийдвэр гаргуулж, зээлийг төлүүлэхгүй байх боломжтой гэдгийг сүүлийн 20 гаруй жилийн турш сэтгэл судлал болон зан төлөвийн эдийн засгийн салбарын судлаачид хүн төрөлхтөнд батлан харуулсаар ирсэн. Гэвч дэлхий дахинд тус нөлөөг бүрэн анзааралгүй, өнөөг хүртэл зөвхөн сайн зээлийн түүхтэй, орлогоо нотлох баримттай хүнд л зээл олгохыг сонгосоор байна. Шинжлэх ухааны нээлтийг үл ойшоосноос болж дэлхий дахинд зээлийн түүх, барьцаа нотолгоогүй улмаас зээл авч чаддаггүй 1.7 тэрбум гаруй хүн ядууралд ойртсоор байна. Гэвч хүн бүрт зээлийн түүх, санхүүгийн нөөц байхгүй ч сэтгэл зүйн нөөц бүгдэд нь бий. Тиймээс сэтгэл зүйн үнэлгээний аргачлалыг ашигласнаар эрсдэлгүй зээлийн үйлчилгээг хүргэх боломж бүрэн нээлттэй.

Сэтгэл зүйн үнэлгээ буюу психометрик 20-р зуун хүртэл шинжлэх ухааны судалгааны арга зүйд нэвтрээгүй байсан (Thurstone, 1932) бөгөөд Spearman болон Thurstone зэрэг эрдэмтэд сэтгэл зүйн үнэлгээг оруулж ирснээр фактор анализын хэрэглээнд үнэтэй хувь нэмэр оруулсан. Бие хүний сэтгэхүйн чадамж болон зан байдлын хэв загварыг хэмжих зорилготой статистикийн болон судалгааны хэмжигдэхүүнд тооцогддог бөгөөд зорилгоосоо хамааран олон төрөл байдаг ба бодол, мэдрэмж, хандлага, үйлдлийг судлахад чиглэсэн энгийн ойлгомжтой асуулуудаас бүрдэнэ. Орчин үед технологитой хослуулснаар орон зайнаас үл хамааран хүнийг богино хугацаанд судлах чухал хэрэглэгдэхүүн болоод байгаа билээ. Ажилгалтын

аргаас ялгаатай нь хүн өөрийн мэдэрч буйгаараа асуултад хариулдаг тул үр дүнд гадны нөлөө орохгүй бодитой байдаг. Гэвч хүнийг судалж байгаа аргачлал нь шинжлэх ухаанд хүлээн зөвшөөрөгдсөн, найдварт чанарыг хангасан байх ёстой. Сэтгэл зүйн тест гэсэн нэрээр хүнээс юуг ч хамаагүй асууж хариултад нь тулгуурласан дүгнэлт гаргаж болохгүй. Аливаа судалгааны зорилгоор ашиглагдаж буй сэтгэл зүйн үнэлгээ нь хамгийн наад зах нь найдвартай, баталгаат чанар ба тохирох чанарын шинжилгээний шалгуурыг давсан байх шаардлагатай.

Сэтгэл зүйн үнэлгээ нь үүссэн цагаасаа эхлэн боловсрол, сэтгэл судлал, сэтгэцийн эрүүл мэнд, нийгэм судлалд түлхүү ашиглагддаг бөгөөд санхүүгийн зах зээлд зээлийн эрсдэлийн үнэлгээнд ашиглагдаж эхлээд 10 гаруй жил болоод байна. Гэвч энэ хугацаанд дэлхий нийтээрээ хэрэглэж болохуйц зээлийн эрсдэлийг бүрэн тодорхойлж чадахуйц сэтгэл зүйн үнэлгээний аргачлал өнөөг хүртэл бүтээгдээгүй. Энэ нь зээлдэгчийн зан төлөв, эргэн төлөлтийн хандлагад харьяалагддаг улс орон, үндэстний сэтгэл зүйн онцлог, газар нутгийн соёл, үнэт зүйл, нийгмийн хэм хэмжээ нөлөөлдөгтэй холбоотой байж болзошгүй юм.

Иймээс 2018 онд хамгийн анх Монгол хүний хариуцлага, хэлсэндээ хүрэх байдал, зарчимч зэрэг зан төлөвийн онцлогийг онол болон туршилт судалгаануудад тулгуурлан тодорхойлсон байдаг. Тус сэтгэл зүйн аргын тусламжтай хувь хүн зээлээ цагт нь буцаан төлөхөд санхүүгийн боломжоос нь илүүтэйгээр тухайн хүний хариуцлага, мөнгөнд хандах хандлага, өөрийн хяналт, өгөх хандлага гэсэн сэтгэл зүйн хүчин зүйлс нөлөөлдөг болохыг илрүүлжээ. Энэхүү судалгааны ажлаа батлан, дэлхийн нэр хүндтэй MDPI (Academic Open Access Publishing)–н Behavioral Sciences сэтгүүлд “Effect of Psychological Factors on Credit Risk: A Case Study of the Microlending Service in Mongolia” нэртэйгээр нийтлүүлсэн.

ТОГТВОРТОЙ САНХҮҮЖИЛТ

ТОГТВОРТОЙ ХӨРӨНГИЙН БИРЖ

» Эхлэл 1-р нүүрт

Зах зээлийн судалгаа, хөгжлийн газрын референт Н.Нарантуяа

12 ХАРИУЦЛАГАТАЙ
ИРГЭДИЙН
ОРОЛЦООГ
ДЭМЖИХ

Нэгдсэн Үндэстний Байгууллагаас хариуцлагатай хөрөнгө оруулалтыг бий болгох зорилгоор Тогтвортой хөрөнгийн зах зээлийн санаачилгыг байгуулсан. Тогтвортой хөрөнгийн зах зээлийн санаачилгад хөрөнгийн биржүүд болон санхүүгийн зохицуулагч нар нэгдэх ба Тогтвортой хөгжлийн хэд хэдэн зорилгыг

хэрэгжүүлэхэд хөрөнгө оруулалтыг чиглүүлэн ажилладаг. Тогтвортой хөгжлийн зорилго (ТХЗ)-ын 12.6 дахь зорилтын хүрээнд хөрөнгийн биржийн хувьд компаниудыг байгаль орчин, нийгэм, засаглалын ил тод байдлын аргачлал, маягтыг гаргаж, хөрөнгө оруулагчдыг мэдээллийн ил тод байдлаар хангадаг. Тогтвортой хөрөнгийн зах зээлийн санаачилгад 107 бирж, 16 зохицуулагч нэгдсэнээс байгаль орчин, нийгэм, засаглалын тайлангийн загварыг нийт гишүүнчлэлтэй биржүүдийн 53 хувь буюу 57 нь уг тайлагналын стандартыг гарган хувьцаат компаниуд тайлагнах болсон.

13 УУР АМЬСГАЛЫН
ӨӨРЧЛӨЛТИЙН
ҮР НӨЛӨӨГ
БАГАСГАХ

ТХЗ-ын 13.3 дахь зорилтод хүрэхэд ногоон санхүүжилтийг бий болгох төлөвлөгөөг гаргасан ба 38 хөрөнгийн бирж буюу нийт гишүүнчлэлтэй биржүүдийн 35 хувь нь ногоон санхүүжилтийн орчинг бүрдүүлээд байна. Хөрөнгийн бирж нь үнэт цаас гаргагч, хөрөнгө оруулагч нарыг нэг цэгт уулзуулах үүргийг гүйцэтгэдгийн хувьд байгаль

орчин, нийгэм, засаглалын мэдээллийг түгээх платформ, тогтвортой хөрөнгийн дэд бүтцийг бүрдүүлэгч, альтернатив санхүүжилт, жижиг, дунд үйлдвэрлэл эрхлэгч нарыг санхүүжүүлэгчтэй нь холбогч гүүр юм.

5 ЖЕНДЭРИЙН ЭРХ ТЭГШ
БАЙДЛЫГ ХАНГАХ

ТХЗ-ын 5.5 дахь зорилт буюу хүйсийн тэгш байдлыг хангахад 95 хөрөнгийн бирж буюу гишүүнчлэлтэй биржүүдийн 93 хувь нь нэгдсэн. Жил бүрийн Олон улсын эмэгтэйчүүдийн эрхийг хамгаалах өдөр хүйсийн эрх тэгш байдлын ач холбогдлыг эргэн санах зорилгоор тус 95 бирж "Хонх цохих" арга хэмжээг зохион байгуулдаг байна.

8 ЗОХИСТОЙ ХӨДӨЛМӨР
БА ЭДИЙН ЗАСГИЙН
ӨСӨЛТИЙГ ДЭМЖИХ

ТХЗ-ын 8.3 дахь зорилтод хүрэхэд нийгэмд ажил эрхлэлтийг бий болгодог жижиг, дунд үйлдвэрлэлийн санхүүжилтийн таатай орчинг бүрдүүлэх юм. Үүний тулд хөрөнгийн биржүүд санхүүжилтийн эрэлт талаас засаглалыг сайжруулах, нийлүүлэлт талаас таатай орчныг бүрдүүлэх чиглэлд ажиллаж байна.

10 ТЭГШ БҮС
БАЙДЛЫГ
БҮҮРҮҮЛЭХ

ТХЗ-ын 10.5 дахь зорилтод хүрэхэд Тогтвортой хөрөнгийн биржийн санаачилга нь 70 гаруй хөрөнгийн зах зээлийн оролцогчдоос бүрдсэн ажлын хэсэгтэй хамтран ажиллаж байгаа бөгөөд хөрөнгийн зах зээлийн зохицуулагч нь тогтвортой хөрөнгийн зах зээлийг бүрдүүлэхэд шаардлагатай 5 зорилго бүхий төлөвлөгөөг боловсруулжээ.

Хөрөнгийн биржүүд байгаль орчин, нийгэм, эдийн засгийг тэнцвэртэйгээр хөгжүүлэх зорилгын төлөө хамтарч ажиллаад 10 жилийн үр дүнгээ дүгнэсэн байна. Харин манайд үйл ажиллагаа явуулдаг хөрөнгийн биржүүд тогтвортой хөгжилд нэгдэхэд бэлэн байгаа юу?, хөрөнгө оруулагчдыг ногоон санхүүжилтэд хөрөнгө оруулахад, үнэт цаас гаргагчдыг ногоон бонд гаргахад ямар хөшүүргээр сэдэлжүүлэх талаар Сэтгүүлийнхээ дараагийн дугаараар та бүхэндээ хүргэе.

СУДЛААЧИЙН ИНДЭР

МОНГОЛ УЛСЫН САНХҮҮГИЙН ХҮРТЭЭМЖИЙГ ҮНЭЛЭХ ТҮҮВЭР СУДАЛГАА

/2018 он /

Гүйцэтгэсэн: “Эн-Ар-Си-Си”ХХК

Энэхүү судалгааны ажилд дурдагдсан санал, дүгнэлт нь зөвхөн хувь судлаачдын байр суурийг илэрхийлэх бөгөөд Санхүүгийн зохицуулах хорооны албан ёсны байр суурийг илэрхийлэхгүй болно.

ХУРААНГҮЙ

Энэхүү судалгаа нь Монгол Улсын санхүүгийн үйлчилгээний хүртээмжийг үнэлэх зорилготой юм. Судалгааг Санхүүгийн зохицуулах хороо ЭН-АР-СИ-СИ ХХК хамтран 2018 оны 6-аас 8 сард хийж гүйцэтгэлээ.

Судалгааг энгийн санамсаргүй түүврийн аргаар хийсэн. Судалгаанд гар утастай иргэдийн жагсаалтаас 1600 насанд хүрэгчдийг санамсаргүй сонгон оролцуулсан бөгөөд оролцогчдоос асуулгын аргаар мэдээлэл цуглуулсан. Асуулга нь нийт 7 бүлэгтэй бөгөөд иргэдийн ерөнхий нийгэм эдийн засгийн шинж чанар, хуримтлал, санхүүгийн үйлчилгээ авч буй байдал, банкны данс, мобайл болон интернет банкны хэрэглээ, зээл болон даатгалын тухай асуултуудаас бүрдэнэ. Иргэдээс утсаар ярилцлага авах аргаар мэдээлэл цуглуулсан.

Тайлан дараах бүтэцтэй. Нэгдүгээрт бүлэгт Монгол Улсын санхүүгийн хүртээмжийн талаар, хоёрдугаарт бүлэгт санхүүгийн хүртээмж авахад учирч буй саад, гуравдугаарт бүлэгт банкны үйлчилгээний хэрэглээ ба орлогын эх үүсвэр, дөрөвдүгээр бүлэгт хэрэглэгчдийн хадгаламжийн хандлагын талаар, тавдугаар бүлэгт мобайл болон цахим банкны хэрэглээний байдал, зургаа дугаар бүлэгт иргэдийн даатгалын үйлчилгээний хэрэглээний талаар, төгсгөлийн бүлэгт дүгнэлт бичигдсэн болно.

Түлхүүр үгс: санхүүгийн хүртээмж, санхүүгийн үйлчилгээ, цахим банк, хуримтлал

JEL ангилал: A20, E21, G5, G21, I22

УДИРТГАЛ

Энэхүү тайланд 2018 оны байдлаар Монгол Улсын санхүүгийн хүртээмжийг эрэл талаас нь буюу түүврийн аргаар судалсан шинжилгээг нэгтгэн орууллаа. Шинжилгээг санамсаргүй байдлаар сонгосон 1600 иргэдээс нийт 7 бүлэг бүхий асуулга судалгааг авч хийлээ. Асуулга нь иргэдийн ерөнхий нийгэм эдийн засгийн шинж чанар, хуримтлал, санхүүгийн үйлчилгээ авч буй байдал, банкны данс, мобайл болон интернет банкны хэрэглээ, зээл болон даатгалын тухай асуултуудаас бүрдэнэ.

Санхүүгийн хүртээмжийн үндсэн үзүүлэлтээрээ МУ ижил төстэй орнуудтай харьцуулахад харьцангуй өндөр байна. Тухайлбал, банканд данстай иргэдийн эзлэх хувь гэдэг үзүүлэлтээр өндөр хөгжилтэй орнуудын түвшинд байна. МУ-ын иргэдийн 94.5 хувь нь ямар нэгэн байдлаар албан ёсны санхүүгийн үйлчилгээнд хамрагддаг байна. Тухайлбал, иргэдийн 92.1 хувь нь дансаа идэвхтэй ашигладаг бөгөөд 91.9 хувь нь банк, 9.3 хувь нь ББСБ, 3.4 хувь нь ХЗХ-гоор үйлчлүүлдэг. Судалгаанд оролцогчдын 5.2 хувь нь санхүүгийн секторын гадна буюу үйлчилгээ хүртэхгүй байна.

Санхүүгийн үйлчилгээний хүртээмж бүсээр бага зэрэг ялгаатай байна. Хангай болон төвийн бүсэд санхүүгийн үйлчилгээний хүртээмж бусад орон нутгаас харьцангуй бага байна. Хүйс болон сууцны төрлөөр санхүүгийн хүртээмж ялгаагүй байна. Харин ажил хийдэггүй иргэдийн хувьд санхүүгийн хүртээмж ажилтай иргэдээс харьцангуй бага байна.

Банкны үйлчилгээний хамрах хүрээ маш сайн байгаа хэдий ч банкны үйлчилгээ авдаг давтамж болон данс ашиглалтаар иргэд ялгаатай байна. Ялангуяа, байршил болон сууцны төрлөөс хамааран ялгаа их байгаа юм. Тухайлбал, орон сууцанд амьдардаг иргэдийн 52.5 хувь нь өдөр бүр болон долоо хоног тутамд банкны үйлчилгээ авдаг бол гэр хороололд амьдардаг иргэдийн хувьд энэ нь 17.5 пунктээр бага байна. Энэ хувь хотын иргэдийн хувьд 46.2% байхад хөдөөний иргэдийн хувьд 39.2%.

Монгол Улсын хэмжээнд иргэд тогтмол үйлчлүүлдэг банкны салбартаа очихын тулд дунджаар 1350 төгрөг 16 минут зарцуулдаг байна. Энэхүү зардал болон хугацаа нь бүсээр ялгаатай. Тухайлбал, Хангайн бүсийн иргэд банкны салбарт очихдоо хамгийн их зардал болон хугацааг зарцуулж буй нь улсын дунджаас 723 төгрөг, 3 минутаар илүү байна.

Бүс нутгаас гадна, банкны салбар орох болон АТМ орох нь сууцны төрлөөс хамааран нэлээд ялгаатай байна. Орон сууцанд амьдардаг иргэд банкны салбар орохдоо 770 төгрөг зарцуулж буй нь гэр хорооллын иргэдтэй харьцуулахад 2.3 дахин бага, 12.4 минут зарцуулж буй нь гэр хорооллын иргэдийнхээс 1.6 дахин бага байна. АТМ орох зардал, хугацааны хувьд ялгаа бүр их.

Иргэдийн банкны үйлчилгээнд хамрагддаг байдал нь тийм ч их ялгаатай биш байхад энэ байдал мобайл болон интернет банкны хувьд арай өөр байгаа юм. Мобайл болон интернет банкны үйлчилгээ банкны дараа хамгийн өргөн авдаг үйлчилгээнүүд боловч банкны үйлчилгээнээс ялгаатай нь байршил, сууцны төрөл, хүйс, орлого болон ажил эрхлэлтийн байдлаас хамааран эрс ялгаатай байна. Нийт иргэдийн 49.1 хувь нь мобайл банкны үйлчилгээ, 27 хувь нь интернет банкны үйлчилгээ авдаг бөгөөд үүн дотроо 19.8 хувь нь мобайл болон интернет аль алиныг нь ашигладаг, 29.3 хувь нь зөвхөн мобайл банк, 7.2 хувь нь зөвхөн интернет банк, 43.7 хувь нь алиныг нь ч ашигладаггүй байна. Энэ дүр зураг бүсээр нэлээд ялгаатай.

Сүүлийн 12 сарын хугацаанд нийт хэрэглэгчдийн 30.3 хувь хуримтлалдаа мөнгө хийсэн бөгөөд дийлэнх (94.8 хувь) нь банканд хадгалдаг гэжээ. Харин нийт хэрэглэгчдийн 35.4 хувь сүүлийн 6 сард зээл авсан бөгөөд нийт иргэдийн 23.1 хувь нь арилжааны банкаас,


7.9 хувь нь ломбарднаас, 6.5 хувь нь ББСБ-аас, 4.9 хувь нь хувь хүнээс зээл авчээ. Хуримтлалдаа мөнгө хийсэн болон зээл авсан эсэх нь хэрэглэгчийн бүлгээр болон бүс нутгаар харилцан адилгүй байна.

Хэрэглэгчдийн 70 хувь нь ямар нэг сайн дурын даатгалд хамрагддаггүй бөгөөд тэдний 40 хувь нь даатгалын талаар мэдэхгүй учраас, 26 хувь нь хэрэгцээ, шаардлага байхгүй учраас даатгалд хамрагдаагүй гэж хариулжээ. Сайн дурын даатгалд хамрагдалт 18.9 хувьтай байгаа бол уг даатгалд хамрагдсан эсэхээ мэдэхгүй иргэд 2 орчим хувь байна. Өндөр орлоготой, дээгүүр боловсролтой, сууцанд амьдардаг, зээл авсан, үл хөдлөх хөрөнгө эзэмшдэг, хуримтлал хийдэг, ажил эрхэлдэг иргэдийн хувьд сайн дурын даатгалд хамрагдалт сайн байна. Даатгалын хэрэгцээ шаардлагын хувьд даатгалын төрлөөс хамааран иргэдийн таашаал өөр өөр байна.

САНХҮҮГИЙН ХҮРТЭЭМЖ АВАХАД УЧИРЧ БҮЙ СААД

Дэлхийн банкны “Global Findex Database 2017” тайланд тооцооноор дэлхийн хэмжээнд нийт насанд хүрсэн иргэдийн 31 хувь нь банканд дансгүй байна. Манай улсын хувьд энэ үзүүлэлт эрс бага буюу нийт иргэдийн 4.5 хувь нь банканд дансгүй байна. Эдгээр дансгүй иргэдийг нийгэм, эдийн засгийн шинж чанараар нь харвал хүйс, нас, сууцны төрөл, оршин суугаа газар, ажил эрхлэлтийн байдлаасаа хамааран ялгаатай байна. Дэлхийн жишигтэй харьцуулахад мөн ялгаатай зүйлс байна. Тухайлбал, дансгүй иргэдийн дийлэнх нь эмэгтэйчүүд, орлого багатай, эдийн засгийн идэвхгүй байгаа нь дэлхийн нийтэд түгээмэл байдаг нь манай улсын хувьд ч мөн адил байна. Харин дэлхийн бусад улсуудын хувьд насаар залуу, боловсрол багатай иргэд банканд дансгүй байх нь элбэг байдаг бол манай улсын хувьд эсрэг дүр зураг ажиглагдлаа.

Зураг. Банканд дансгүй иргэд, хүйс болон орлогын бүлгээр




БАНКНЫ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ХЭРЭГЛЭЭ БА ОРЛОГЫН ЭХ ҮҮСВЭР

Өмнөх бүлгүүдээс үзэхэд санхүүгийн үйлчилгээний хүртээмжид орлогын эх үүсвэр нөлөөтэй байсан. Иймд энэ бүлэгт эдгээрийн хамаарлыг авч үзье. Хадгаламж болон банкны үйлчилгээ авдаг давтамжийг Зурагт харуулж байна. Хадгаламж хийдэг иргэдийн 68.8


хувь нь сард нэгээс доошгүй удаа хадгаламж хийдэг. Харин банканд данстай иргэдийн 43 хувь нь долоо хоногт ядаж нэг удаа банкаар үйлчлүүлдэг.

Зураг. Хадгаламж хийх болон банкны үйлчилгээ авдаг давтамж




Орлогын эх үүсвэр хадгаламж хийдэг давтамжтай хамааралтай байна. Тухайлбал, цалингийн орлоготой хуримтлалтай хүмүүсийн 72.3 хувь нь сард ядаж нэг удаа хуримтлал хийдэг бол тэтгэвэр, тэтгэмж авдаг хуримтлалтай хүмүүсийн 50 гаруй хувь нь хуримтлал хийдэг байна.

Зураг. Хадгаламж хийх давтамж орлогын эх үүсвэрээр



Банкны үйлчилгээ авдаг давтамжийг мөн орлогын эх үүсвэрээр нь харья. Цалингийн орлоготой хүмүүсийн 91.2 хувь нь сард нэгээс олон удаа банкны үйлчилгээ авч байхад, тэтгэмж болон тэтгэвэр авдаг хүмүүсийн 72-76 хувь нь сард нэгээс олон үйлчилгээ авдаг байна.

Зураг. Банкны үйлчилгээ авах давтамж орлогын эх үүсвэрээр



Эндээс үзэхэд цалингийн орлоготой хүмүүсийн банкаар үйлчлүүлэх болон хадгаламж хийх давтамж тэтгэвэр, тэтгэмж авдаг хүмүүсийнхээс илүү өндөр байна.

ДҮГНЭЛТ, САНАЛ

Санхүүгийн хүртээмжийн үндсэн үзүүлэлтээрээ МУ ижил төстэй орнуудтай харьцуулахад харьцангуй өндөр байна. Тухайлбал, банканд данстай иргэдийн эзлэх хувь гэдэг үзүүлэлтээр өндөр хөгжилтэй орнуудын түвшинд байна. МУ-ын иргэдийн 94.5 хувь нь ямар нэгэн байдлаар албан ёсны санхүүгийн үйлчилгээнд хамрагддаг байна. Тухайлбал, иргэдийн 92.1 хувь нь дансаа идэвхтэй ашигладаг бөгөөд 91.9 хувь нь банк, 9.3 хувь нь ББСБ, 3.4 хувь нь ХЗХ-гоор үйлчлүүлдэг. Судалгаанд оролцогсдын 5.2 хувь нь санхүүгийн секторын гадна буюу үйлчилгээ хүртэхгүй байна.

Санхүүгийн үйлчилгээний хүртээмж бүсээр бага зэрэг ялгаатай байна. Хангай болон төвийн бүсэд санхүүгийн үйлчилгээний хүртээмж бусад орон нутгаас харьцангуй бага байна. Хүйс болон сууцны төрлөөр санхүүгийн хүртээмж ялгаагүй байна. Харин ажил хийдэггүй иргэдийн хувьд санхүүгийн хүртээмж ажилтай иргэдээс харьцангуй бага байна.

2017 оны байдлаар дэлхийн хэмжээнд нийт насанд хүрсэн иргэдийн 31 хувь нь банканд дансгүй байна. Манай улсын хувьд энэ үзүүлэлт эрс бага буюу нийт иргэдийн ердөө 4.5 хувь нь банканд дансгүй байна. Банканд дансгүй гэж өөрөө мэдээлсэн болон данстай хэдий ч түүнийгээ огт ашиглахгүй байгаа хүмүүсийг энд оруулж тооцсон. Энэхүү банкны дансгүй иргэд ажил эрхлэлтийн байдал, нас, боловсрол, байршил, орлого болон сууцны төрлөөс хамааран нэлээд ялгаатай байна. Гол төлөв ажилгүй, 25-аас дээш настай, орлого бага, гэр хорооллын иргэд дансгүй байх нь олон байна. Тухайлбал, дансгүй иргэдийн 36 хувь нь хамгийн бага орлоготой бүлгийн иргэд байхад 7 хувь нь хамгийн өндөр орлоготой бүлгийн иргэд байна. Мөн түүнчлэн, дансгүй иргэдийн 63.8 хувь нь эдийн засгийн идэвхтэй иргэд, 36.2 хувь нь идэвхгүй иргэд байна. Данс эзэмшихгүй шалтгаанууд дунд хамгийн өндөр хувь эзэлж буй нь дундаа данстай байх нь зардал багатай (20%) гэнээс үзвэл эдгээр иргэдийн 20 хувь нь данс огт хэрэглэдэггүй биш байгаа юм.

Монгол Улсын хэмжээнд иргэд тогтмол үйлчлүүлдэг банкны салбартаа очихын тулд дунджаар 1350 төгрөг 16 минут зарцуулдаг бол АТМ орохын тулд 960 төгрөг 15 минут зарцуулдаг байна. Банкны салбар

болон АТМ орох зардал болон хугацаа нь хот хөдөөгөөр болон сууцны нөхцөлөөр нэлээд ялгаатай байна. Хөдөө амьдардаг бөгөөд гэр хороололд амьдардаг иргэд илүү их зардал, хугацаа зарцуулдаг. Хангайн бүсийн иргэд банкны үйлчилгээ авахдаа хамгийн их зардал, хугацааг зарцуулдаг. Улаанбаатар хотын иргэд хамгийн бага зардал, хугацаа зарцуулж байна. Улаанбаатар хотод АТМ орох нь банкны салбар орохоос хэд дахин зардал багатай байхад хөдөөд эсрэгээрээ банкны салбар орох нь АТМ орохоос зардал багатай байна.

Банкны үйлчилгээний хамрах хүрээ нь манай улсын маш сайн бөгөөд энэ нь хаана амьдардаг, баян эсвэл ядуу зэргээс хамааран тийм ч их ялгаатай биш хэдий ч банкны үйлчилгээ авдаг давтамж орон сууцанд амьдардаг, хөдөөний иргэдийн хувьд бага байгаа юм. Тухайлбал, орон сууцанд амьдардаг иргэдийн 52.5 хувь нь хамгийн багадаа л долоо хоног тутамд банкны үйлчилгээ авдаг бол гэр хороололд амьдардаг иргэдийн хувьд энэ нь 17.5 пунктээр бага. Иргэд ажил эрхлэлтийн байдлаас хамааран банкны үйлчилгээ авах нь өөр өөр байж болох хэдий ч ажилтай иргэдийн хувьд мөн л хаана амьдардаг, сууцны нөхцөл зэргээс хамааран банкны үйлчилгээ авах давтамж ялгаатай байна.

2017 оны байдлаар данс идэвхтэй ашиглаж буй нийт иргэдийн 86 хувь нь харилцах, 31 хувь нь хадгаламжийн, 12 хувь нь хугацаатай хадгаламжийн, 6 хувь нь зээлийн, 13 хувь нь дебит карт, 2 хувь нь гадаад валютын данстай, 2 хувь нь кредит карттай байна. Эзэмшиж буй дансны төрөл нь байршил,

хүйс зэргээрээ тийм ч их ялгаатай биш байна. Иргэдийн 44 хувь нь цалингаа авахын тулд, 35 хувь нь мөнгөө найдвартай газар байлгах үүднээс, 24 хувь нь төлбөр авахын тулд мөн 24 хувь нь халамж тэтгэмжийн мөнгө хүлээн авахын тулд данстай болсон гэжээ. Нийт данстай иргэдийн 32 хувь нь 2010 оноос өмнө нээлгэсэн, харин 36 хувь нь дансаа 2010–2018 оны хооронд нээлгэжээ. Хамгийн их данс нээлгэсэн он 2008 он байна. Идэвхтэй данс ашиглаж буй иргэдийн 65.7 хувь нь нэгээс олон данстай байна.

Нийт иргэдийн 49.1 хувь нь мобайл банкны үйлчилгээ, 27 хувь нь интернет банкны үйлчилгээ авдаг бөгөөд үүн дотроо 19.8 хувь нь мобайл болон интернет аль алиныг нь ашигладаг, 29.3 хувь нь зөвхөн мобайл банк, 7.2 хувь нь зөвхөн интернет банк, 43.7 хувь нь алиныг нь ч ашигладаггүй байна. Мобайл болон интернет банкны үйлчилгээг хотод, орон сууцанд амьдардаг, орлого өндөртэй иргэд илүүтэй хэрэглэж байна.

Нийт хэрэглэгчдийн 35.4 хувь нь өнгөрсөн 6 сарын хугацаанд санхүүгийн албан болон албан бус байгууллагуудаас зээл авсан бөгөөд хамгийн их үйлчлүүлсэн байгууллага нь арилжааны банк байна. Үүний дараагаар ломбард (18 хувь), ББСБ орж байна. Албан бус санхүүгийн үйлчилгээ буюу ломбард, хувь хүнээс авч байгаа зээл нэлээд их хувийг (30 орчим хувь) эзэлж байна. Хамгийн ядуу бүлгийн зээлд хамрагдалт хамгийн бага байна.

Энэхүү судалгааны үр дүнгээс харахад иргэдийн хадгаламжийн зах зээлд арилжааны банк илт давамгайлж байна.

Үүнтэй харьцуулахад иргэдийн зээлийн зах зээлд арилжааны банк харьцангуй бага хувь (53 хувь) эзэлж байна. Хэрэглэгчид зээл авахдаа бусад санхүүгийн байгууллагаар нэлээд үйлчлүүлдэг ажээ. Тухайлбал ББСБ-аас гадна, албан бус сектор буюу ломбард, хувь хүнээс зээл авдаг байна.

Хэрэглэгчдийн 70 хувь нь сайн дурын даатгалд хамрагддаггүй бол 20 орчим хувь нь ямар нэг сайн дурын даатгалд хамрагддаг гэжээ. Бүлгээр харахад сүүлийн нэг жилийн хугацаанд хуримтлалдаа мөнгө хийсэн иргэдийн сайн дурын даатгалд хамрагдалт хамгийн өндөр байна. Хамгийн хэрэгцээ шаардлагатай даатгалаар эрүүл мэндийн даатгал, түүний дараа гэнэтийн осол, эмчилгээний даатгал болон тэтгэврийн даатгал орж байна. Сайн дурын даатгалд хамрагдаагүй шалтгаануудыг даатгалын талаар мэдэхгүй учраас гэсэн хариулт тэргүүлж байгаа бөгөөд дараагийн гол шалтгаан нь хэрэгцээ шаардлага байхгүй гэсэн шалтгаан байна.

ЭХ СУРВАЛЖ

- “Financial Services Demand Side Survey Tonga”, National Reserve Bank of Tonga, 2016
- Asli Demircuc–Kunt, Leora Klapper, Dorthier Singer, Saniya Ansar, Jake Hess “The Global Findex Database 2017: Measuring Financial Inclusion and the Fintech Revolution”, World Bank Group, 2018
- IMF Database “Financial Access Survey, Tracking Access to Financial Services”, IMF, October 2017



САНХҮҮГИЙН БОЛОВСРОЛ

САНХҮҮГИЙН ЛУЙВАР ПИРАМИД БОЛОН ПОНЗИ СХЕМ

Эрсдэл ба санхүү

Хүн өдөр бүр нийгмийн харилцаанд ордог шиг санхүүгийн харилцаанд орж ямар нэг шийдвэрийг гаргаж байдаг. Харин эрсдэл бол нийгмийн амьдралын бүхий л салбарыг хамарч, хүний хийж буй үйлдэл бүрт ямар нэг хэмжээгээр агуулагдаж байдаг тул бид эрсдэлтэй байнга нүүр тулдаг. Санхүүгийн үүднээс авч үзвэл, эрсдэл нь хувь хүнд учирч болзошгүй гарз, хохирол, оруулсан хөрөнгөө алдах магадлал юм.

Санхүүгийн байгууллага бүр өөрийн гэсэн онцлог бүтээгдэхүүн, үйлчилгээтэй ба түүнээс хамааран эрсдэл болон ашгийн түвшин ялгаатай. Өгөөж, ашиг хэдий чинээ их байна, эрсдэл төдий чинээ их, нөгөө талаас эрсдэл нэмэгдэх тусам санхүүгийн аюулгүй байдал алдагддаг. Эрсдэл санхүүгийн аюулгүй байдал гэсэн ойлголт хоорондоо салшгүй холбоотой бөгөөд харилцан нөлөөлж байдаг хүчин зүйлүүд юм. Аливаа төрлийн хөрөнгө оруулалт үргэлж тодорхой хэмжээний эрсдэл дагуулж байдгийн дотор ашиг орлого олох боломжоо алдах, худалдан авсан хувьцаанаас алдагдал хүлээх, хөрөнгө оруулсан компани төлбөрийн чадваргүй болж дампуурах, олгосон зээл найдваргүй болох зэрэг санхүүгийн эрсдэл учирч болзошгүй.

Луйвар гэж юу вэ?

Монгол хэлний тайлбар толь бичигт луйвар гэдэг үгийг булхай заль мэх гэж тайлбарласан байдаг бол Эрх зүйн эх толь бичигт залилан мэхлэх нь өмчлөх эрхийн эсрэг гэмт хэрэг бөгөөд хүч хэрэглээгүй ашиглан шамшигдуулах хэлбэр хэмээн тодорхойлсон байна. Мөн залилан мэхлэх нь бусдын эд хөрөнгө, эсхүл түүний өмчлөх эрхийг хуурч мэхлэх, итгэл эвдэх замаар олж авах үйлдэл юм. Өөрөөр хэлбэл санаатайгаар үнэнийг гуйвуулах, эсвэл үнэнийг зориудаар нуун дарагдуулснаас хууртагч өөрийн хөрөнгийг хууран мэхлэгчид сайн дураар өгөх явдал хэмээн тодотгож болно.

Луйвар маш олон төрөл бөгөөд цаг хугацааны явцад өөрчлөгдөж, тухайлбал, интернет бий болсноор үндэстэн, тив дамнасан шинжтэй болон тэлсэн. Төрөл зүйлээсээ хамаараад өөрийн гэх нэршилтэй. Санхүүгийн луйвар нь банк, санхүүгийн байгууллагын цахим сүлжээнд хууль бусаар нэвтрэх, гэрээний зүйл заалтаар дамжуулах, мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх замаар, хэвлэл мэдээллийн хэрэгсэл, олон нийтийн цахим сайтыг санхүүжүүлэх гэх мэт хэлбэрүүдээр илэрдэг. Олон хүн хамрагдаж хохирч байдгаараа санхүүгийн луйвраас хамгийн их эрсдэлтэй нь санхүүгийн пирамид болон понзи схем байна.

Санхүүгийн пирамид

Танд өндөр өгөөж, ашиг амласан хөрөнгө оруулалт санал болгож, найз нөхдөө идэвхтэй хамруулах санал тавьж байна уу? Болгоомжтой байгаарай, зүгээр сууж байгаад ашиг хүртэх боломжгүй. Амжилттай мэт харагдаж буй хөрөнгө оруулалтын компани ч санхүүгийн луйвар байж болзошгүй.

Санхүүгийн пирамид бол шинээр гишүүн элсүүлэх замаар үйлдэгддэг санхүүгийн луйврын төрөл юм. Пирамид схемийн сурталчлагч богино хугацаанд өндөр өгөөж авах боломжийг амлан шинээр элсэгчдийн төлсөн гишүүнчлэлийн мөнгийг өмнө элссэн гишүүдэд өгөх замаар үйл ажиллагаа явуулж, бүтээгдэхүүн үйлчилгээ бодитоор зарагддаггүй.

Луйварчид пирамидын схемийг олон нийтийн сүлжээ, интернет, компанийн веб сайт, бүлгийн танилцуулга, Youtube видео болон бусад хэрэгслээр байнга сурталчилж байдаг.

Хууль ёсны олон түвшний маркетингийн /шууд худалдааны/ компаниуд гишүүн элсүүлж бус бүтээгдэхүүн, үйлчилгээний борлуулалтаас орлого олдог бол пирамид схемийн сурталчлагчид өөрийн луйврын үйлдлийг халхавчлахын тулд бүтээгдэхүүн үйлчилгээ зарах зорилготой хууль ёсны олон түвшний маркетингийн бизнес мэт харагдуулахын тулд ихээхэн хүчин чармайлт гаргадаг.

Пирамид схем хэт том болсноор өмнөх гишүүдэд өгөх өгөөжийг төвлөрүүлэх хэмжээний хөрөнгө оруулалт татах гишүүн шинээр элсүүлж чадахгүйд хүрч, пирамид нурж хүмүүс мөнгөө алдаж эхэлдэг.

Санхүүгийн пирамидын хэлбэрүүд

1. Бодит пирамид

Энэ тохиолдолд пирамидын зохион байгуулагчид бодит байдлыг нуудаггүй. Тэд ажиллах механизмыг үнэмшилтэйгээр тайлбарлаж, итгэл төрүүлэхүйц тооцооллыг ч харуулдаг. Орчин цагт цахим ертөнцийн тусламжтайгаар энэ төрлийн луйварт өртөх хүний тоо өссөөр байна.

2. Хөрөнгө оруулалтын компанийн хэлбэртэй пирамид

Ихэнх луйварчид өөрийн явуулж буй хууль бус үйлдлийг бусдад халхавчилж тайлбарладаг. Тэд өөрсдийгөө хөрөнгө оруулалтын компани мэтээр харуулж, бусдын итгэлийг олохын тулд интернет компани, хөрөнгө оруулалтын төсөл гэх зэргээр нэрлэдэг.

Өндөр ашигтай барилгын бизнес, алт олборлолт, зарим тохиолдолд гайхамшигтай бөгөөд тодорхойгүй үйл ажиллагаанд хөрөнгө оруулах, хувь эзэмшихийг санал болгох зэрэг арга хэлбэр олон байдаг. Зохион байгуулагчдын “гоё” ярианд хүмүүсийн ‘толгой эргэх’ нь бий.

3. Зээлийн байгууллагын хэлбэртэй пирамид

Санхүүгийн луйврын бас нэг хэлбэр бол зээлийн муу түүхээсээ болж банкнаас зээл авч чадахгүйд хүрсэн, эсхүл авсан зээлээ төлж чадахгүй байдалд орсон хүмүүсийг хуурах юм. Пирамид зохион байгуулагчид өөрсдийгөө бичил санхүүгийн байгууллага, бүр зарим тохиолдолд банк мэтээр ойлгуулан итгэл төрүүлж, зээлийн төв, санхүүгийн үйлчилгээний төв гэх зэргээр нэрлэж зээлийн муу түүхийг засаж өгөх, зээлдэгчийг өрөөс чөлөөлөх мэтээр луйврын үйл ажиллагаа явуулдаг. Гэвч төгсгөлд нь хөрөнгө оруулсан хэн ч юу ч олж авахгүй. Тухайн хүн банкны зээлээ төлж барагдуулах үүргээс чөлөөлөгдөхгүйн дээр түүнээс ч илүү мөнгөө алдахад хүрдэг.

4. Бусад хэлбэрийн пирамид

Луйварчид бүтээлч сэтгэлгээтэй улс байдаг тул өмнө дурдсанаас өөр хэлбэрээр ч санхүүгийн луйврыг хийнэ. Санал тавьж буй этгээд бодит компани уу, эсвэл санхүүгийн луйвар уу гэдгийг тогтооход заримдаа төвөгтэй бөгөөд болгоомж хэзээд илүүдэхгүй.

Пирамид схемүүд дараах нийтлэг шинжтэй байдаг:

- Шинээр гишүүн элсүүлэх– Зөвхөн гишүүн элсүүлэхэд төвлөрч, бүтээгдэхүүн үйлчилгээний борлуулалтаас илүүтэйгээр шинээр гишүүн элсүүлснээр илүү их мөнгө авах боломжтой.
- Бодит бүтээгдэхүүн, үйлчилгээ борлуулдаггүй– Зарим луйварчид пирамид схем гэдгийг хууль ёсны /шууд худалдааны/ бизнес мэт харагдуулахын тулд “сонирхолтой бүтээгдэхүүн”-ийг сонгодог. Жишээлбэл, гоо сайхны бүтээгдэхүүн, өргөн хэрэглээний бараа бүтээгдэхүүн гэх мэт.
- Богино хугацаанд өндөр өгөөж амлах– Хурдан хугацаанд өгөх бэлэн мөнгө, ашгийн амлалтууд нь бүтээгдэхүүн, үйлчилгээний борлуулалтын орлогоос бус шинээр гишүүнээр элсэгчдийн хураамжийн орлогоос төлөгддөг.
- Хялбар мөнгө эсвэл пассив орлого– Үнэгүй хоол гэж байдаггүй. Бусдыг гишүүнээр элсүүлэх, веб сайтууд дээр онлайн сурталчилгаа байршуулах зэрэг ажил хийсний хариуд шан харамж санал болгодог.
- Борлуулалтаас олсон орлого байхгүй– Тухайн компани бүтээгдэхүүн, үйлчилгээ борлуулсан орлогоороо үйл ажиллагаагаа явуулдаг эсэхийг лавлаж, аудитаар хянуулсан санхүүгийн тайлан, мэдээг нь харах хэрэгтэй.

Санхүүгийн пирамид луйврын жишээ: Уг схемд оролцогчид нь пирамид хэлбэрээр дээрээсээ доош гэсэн байрлалтай байна. Схемийг гол төлөв нэг хүн эхлүүлдэг бөгөөд пирамидын оройд заларна. Энэ хүн дараагийн нэг хүнийг схемдээ элсүүлж, тодорхой хэмжээний “хөрөнгө оруулалт” хийлгэдэг. Энэ “хөрөнгө оруулалт”-аас эхний хүн ашиг хүртэнэ. Хоёр дахь хүн өөрийн хөрөнгө оруулалтаа нөхөж авахын тулд өөрийнхөө дор дахиад хэдэн хүн элсүүлэх шаардлагатай. Шинээр элссэн хүмүүс мөн л тодорхой хэмжээний “хөрөнгө оруулалт” хийнэ. Эхний хүн өөрийн дор 10 хүн элсүүлэхэд тэдний бага хэмжээний хөрөнгө оруулалтаас ч ашиг олж эхэлнэ.

Хүн бүр доороо 10 хүн элсүүлэхэд гурав дахь үе нь 100 хүнтэй болно. Шинээр элсэж байгаа хүн бүр өөрийг нь элсүүлсэн гишүүнд өөрийн “хөрөнгө оруулалт”-аа төлнө. Доороо гишүүн элсүүлсэн хүн доор байгаа 10 хүний төлсөн мөнгөнөөс өөрийг нь элсүүлсэн хүнд төлсөн мөнгөө хасах хэмжээний буюу 9 хүний “хөрөнгө оруулалт”-ыг өөртөө ашиг болгон авна. Энэ систем нь пирамидын төгсгөлд байгаа хүмүүс нь дээд бүтцээ дэмжиж чадахгүй буюу өөр элсэх хүн үлдэхгүй болтол үргэлжилдэг. Эцэст нь бүх пирамид схем нуран унадаг.

Понзи схем: Өнгөрсөн зууны хориод онд амьдарч байсан Чарльз Понзи гэгч Итали гаралтай цагаач эр понзи схемийн залиланг 1919–1920 онд гаргаж ирсэн бөгөөд эхний хөрөнгө оруулагчдад амласан өгөөжийг шинэ хөрөнгө оруулагчдаас татан төвлөрүүлсэн хөрөнгөөр төлдөг хөрөнгө оруулалтын луйврын нэг төрөл юм.

Америкийн эдийн засаг хурдацтай хөгжиж, иргэд хувьцааны наймаа ид сонирхож эхэлсэн үед Понзи 90 хоногийн дотор хөрөнгө оруулалтыг хоёр дахин өсгөж чадна гэсэн зар тараасан. Тэрээр өөрийн компанийг байгуулж, хүмүүст улс хоорондын шуудангийн төлбөрийн системийн үнийн зөрүүгээс ашиг олсноор мөнгийг богино хугацаанд өсгөж болно гэж итгүүлсэн. Тэр үеийн нэр хүндтэй “The



Boston Post” сонинд Понзийн мөнгөө үржүүлэх “гайхалтай санаа”-ны тухай нийтлэл гарснаар хүмүүсийг улам илүү татсан.

Понзи олон зуун хөрөнгө оруулагчдыг залилж чадсан бөгөөд түүний схем нэг жил гаруй хугацаанд үргэлжилжээ. Хуучин хөрөнгө оруулагчдын ашгийг шинэ хөрөнгө оруулагчдаас татсан мөнгөөр төлөх замаар энэ схем ажилладаг тул сүүлд хөрөнгө оруулсан хүмүүс хохирч үлддэг. Хөрөнгө оруулагчдыг татахын тулд понзи схемийн луйварчид маш бага эсвэл ямар ч эрсдэлгүй өндөр ашиг хүртэх хөрөнгө оруулалтыг амладаг.

Понзи схемчид өөр хууль ёсны орлогогүй тул томрохын хэрээр өмнөх хөрөнгө оруулагчдад амласан өгөөжийг өгч, оршин тогтнохын тулд байнгын шинэ мөнгөний урсгал буюу хангалттай олон шинэ хөрөнгө оруулагч олох шаардлагатай болдог. Тиймээс шинээр хөрөнгө оруулагч элсүүлж чадахгүй, эсхүл өмнөх хөрөнгө оруулагчид олноороо оруулсан хөрөнгөө авч эхлэхэд энэхүү луйврын схем тогтворгүй болж нурдаг бөгөөд залилагч нь байгаа мөнгөө аваад зугтах эсвэл зохицуулалтын байгууллага болон хууль сахиулах байгууллагад баригдсанаар дуусдаг байна.

Понзи схем нь пирамид схемээс илүү удаан хугацаанд үргэлжлэх боломжтой боловч хоёр схем хоёулаа сүйрэх нь гарцаагүй юм.

Понзи схемүүд дараах нийтлэг шинжтэй байдаг:

- Бага эсвэл ямар ч эрсдэлгүй өндөр өгөөж амладаг– Хөрөнгө оруулалт бүр тодорхой хэмжээгээр эрсдэл дагуулдаг бөгөөд өгөөж өндөр байх тусам илүү өндөр эрсдэлтэй байдаг. Баталгаа амласан хөрөнгө оруулалтад болгоомжтой хандах хэрэгтэй.
- Хэт тогтмол өгөөжтэй байх– Аливаа хөрөнгө оруулалт цаг хугацааны туршид өсөх, буурах хандлагатай байдаг. Зах зээлийн нөхцөл байдлаас үл хамааран тогтмол эерэг өгөөжтэй байгаа хөрөнгө оруулалтад болгоомжтой хандах хэрэгтэй.
- Бүртгэгдээгүй хөрөнгө оруулалт– Понзи схемүүд нь ихэвчлэн үнэт цаасны бирж эсхүл зохицуулагч байгууллагуудад бүртгэгдээгүй хөрөнгө оруулалтуудыг ашигладаг. Хөрөнгө оруулах гэж байгаа бол компанийн менежмент, бүтээгдэхүүн, үйлчилгээ, санхүүгийн талаар мэдээллийг авах шаардлагатай ба эрх бүхий байгууллагад бүртгэгдсэн эсэхийг нягтлах хэрэгтэй.
- Тусгай зөвшөөрөлгүй борлуулагчид– Ихэнх понзи схемийг зөвшөөрөлгүй хувь хүмүүс эсхүл бүртгэлгүй компаниуд үүсгэсэн байдаг.
- Нууцлагдмал, тодорхойгүй стратеги– Ойлгомжгүй эсхүл хангалттай мэдээлэл олж чадахгүй бол тухайн хөрөнгө оруулалтаас зайлсхийх хэрэгтэй.

- Баримт бичигтэй холбоотой асуудлууд– Санхүүгийн тайлан дахь алдаанууд нь хөрөнгө оруулалт амласан ёсоор хийгдээгүй байх магадлалтайг харуулна.
- Төлбөр хүлээн авахад хүндрэлтэй– Хэрэв та төлбөр эсхүл мөнгөө авч чадахгүй хүндрэлтэй байвал болгоомжлох хэрэгтэй. Учир нь понзи схем сурталчлагчид хөрөнгө оруулагчдаа мөнгөө буцаан авахаас сэргийлж илүү өндөр өгөөж санал болгодог.

Понзи луйврын жишээ: Залилагч эхний 2 хөрөнгө оруулагчаас 100 төгрөг авна. Анх оруулсан мөнгийг сарын дараа 10 хувийн хүүтэй буцаан төлөхөөр амлана. Залилагч 200 төгрөгийг хүүтэй нь буцааж төлөхийн тулд 3 хөрөнгө оруулагч олох хэрэгтэй болно. 3 хөрөнгө оруулагчаас авсан 300 төгрөгөөр эхний 2 хөрөнгө оруулагчийн 220 төгрөгийг буцааж төлөөд дахин хөрөнгө оруулалт хийхийг зөвлөнө. Шинэ хөрөнгө оруулагчдын мөнгийг авч хуучин хөрөнгө оруулагчдад амласан өгөөжийг өгч, дахин хөрөнгө оруулалт хийхийг ятгаж, олон хүн хамруулахыг санал болгоно. Энэ мэтчилэн ахин хөрөнгө оруулалт хийх хүнгүй болтол үргэлжилдэг байна. Хэрэв залилан үйлдэгч илүү их мөнгө залилахыг хүсвэл хүн бүрээс 100 төгрөгөөс илүү мөнгө авна.

Санхүүгийн пирамид болон понзи схем ижил болон ялгаатай тал, урьдчилан сэргийлэх арга замууд:

Санхүүгийн пирамид болон понзи схемийн төстэй байдал нь: Хоёулаа санхүүгийн луйвар бөгөөд эрсдэлгүй өндөр өгөөж амлаж хөрөнгө оруулалт татдаг, Идэвхтэй үйл ажиллагаа явуулахын тулд тогтмол шинэ хөрөнгө оруулагч татаж эх үүсвэрээ бүрдүүлдэг, Идэвхтэй сурталчилгаа хийж, олон хүн хамруулдаг, Холбогдох эрх бүхий байгууллагад бүртгэлгүй, үйл ажиллагаа явуулах зөвшөөрөл, тусгай зөвшөөрөлгүй зэрэг юм.

Санхүүгийн пирамид болон понзи схемийн ялгаатай байдал нь: Санхүүгийн пирамид схем нь сүлжээний маркетинг дээр суурилдаг бөгөөд мөнгө олохын тулд оролцогчдоос шинэ гишүүн элсүүлэхийг шаарддаг бол Понзи схем нь хөрөнгө оруулалтын менежментийн үйлчилгээ гэж танилцуулдаг тул оруулсан хөрөнгө оруулалтын өгөөж нь хууль ёсны үр ашиг мэт ойлгогддог. Өөрөөр хэлбэл, нэгэнд нь ашиг өгөхийн тулд өөр нэгнээс мөнгийг нь авдаг ба дахин хөрөнгө оруулалт хийхийг ятгаж, олон хүнийг хамруулдаг.

Санхүүгийн пирамид болон схемийн луйвраас урьдчилан сэргийлэх арга замууд: Хамгийн түрүүнд анхаарал хандуулах зүйл бол тухайн үйл ажиллагааг явуулах зөвшөөрөл, тусгай зөвшөөрлийг эрх бүхий байгууллагаас олгосон эсэхийг нягталж, шаардлагатай мэдээллүүдийг баталгаажуулсны үндсэн дээр сонголт хийх нь чухал. Үүнээс гадна таныг өндөр ашигтай төсөл биш, харин луйвар хүлээж буйг илтгэх дараах шинжүүдээр санхүүгийн луйвраас урьдчилан сэргийлэх боломжтой.

1. Таны гэр бүл, хамаатан, найз нөхөд, санхүүгийн мэргэжлийн томоохон байгууллага байсан ч хөрөнгө оруулахаасаа өмнө дараах асуултуудыг заавал асууж, тодорхой болгох шаардлагатай.

- Би хэдэн төгрөгийн хөрөнгө оруулах вэ?
- Хэдий хугацааны дараа ямар өгөөж хүртэх боломжтой вэ?
- Өгөөж нь баталгаажсан эсэх, яаж, хэрхэн баталгаажиж байгаа вэ?
- Хэрвээ өгөөж нь баталгаажаагүй бол хамгийн өндөр боломж болон хамгийн муу эрсдэл нь юу байх вэ?
- Мөнгөө хэзээ, хэрхэн гарган авах боломжтой вэ зэрэг асуулыг асууж тодруулах шаардлагатай. Хөрөнгө оруулалтын мэргэжилтнүүд хөрөнгө оруулалтын талаар ил тод ярьдаг бөгөөд хөрөнгө оруулахаар харж буй хэн бүхэнд ойлгомжтой байдаг.

Хэрэв мэдээллүүд тодорхой биш, эсхүл маш их удаж байвал танд хөрөнгө оруулалтаас татгалзах боломж байна.

Таны хөрөнгө оруулалт хаашаа орж байгаа талаар санаа зовох шаардлагагүй, бид санаа тавих болно гэх зэргээр ятгаж байвал үүнийг нотлох баримтыг шаардах хэрэгтэй. Та өөрийн хөрөнгийг хаана, хэрхэн байршсаныг харж чадахгүй, ямар нэг мэдээлэлгүйгээр үнэлж, тооцоолох боломжгүй юм. Ятгах тусам нягтлах шаардлагатай. Үзүүлэх баримтгүй бол та луйварчинтай учирсан нь гарцаагүй.

2. Хөрөнгө оруулалтын менежментийн шийдвэрийг хэн, хэрхэн гаргаж байгаагаас үл хамааран таны мөнгө санхүүгийн байгууллагад хадгалагдана. Тиймээс та хөрөнгө оруулалт хийж буй компани ямар компани болох, хэрхэн холбоо барих зэрэг мэдээллүүдийг авсан байх, тухайн компани таныг сар бүрийн эсхүл улирлын санхүүгийн тайлан, мэдээллээр хангадаг байх шаардлагатай.

Таны данс таны нэр дээр байгаа эсэхийг шалгах хэрэгтэй. Хэрэв та өөрийн данс руу нэвтрэх боломжгүй бол өөрийн хөрөнгө, хадгаламжийн найдвартай байдлын үүднээс илүү нарийн мэдээллүүдийг авах шаардлагатай.

3. Их сургуулийн диплом, мэргэжлийн гэрчилгээ, албан тушаалын томилолт болон ажлын туршлага зэрэг мэдээллүүдийг шалгах хэрэгтэй.

Үйл ажиллагаагаа тодорхойгүй шалтгааны улмаас тасалдуулсан, тухайн компанийг хайх, холбоо барихад төвөгтэй байх, гэрчилгээ нь тодорхой бус зэрэг шинж тэмдэг илэрвэл зайлсхийх шаардлагатай.

4. Та хөрөнгө оруулалт хийх асуудлаар уулзалт хийх тохиолдолд итгэмжлэгдсэн зөвлөх, өмгөөлөгч зэрэг хүнтэй хамт байж шаардлагатай мэдээллүүдийг авах боломжтой.

Хэрэв уулзалтад өөр хүн авчрах эсхүл тэмдэглэл хөтлөх боломжгүй гэвэл та болгоомжлох хэрэгтэй.

5. Тухайн компани тодорхой, тогтвортой ажлын байртай эсэхийг нягтлах шаардлагатай. Хүндэтгэх шалтгаан, тайлбаргүйгээр өөр ямар нэг газар уулзалт товлох хэрэггүй.

Хэрэв тухайн компани тогтвортой ажлын байргүй, холбогдох ажилтан нь шаардлагатай мэдээллүүдийг өгөхгүй байвал та шийдвэрээ дахин бодож үзэх хэрэгтэй.

6. Танд өндөр боломжтой мэт харагдаж, таны сонирхлыг ихээхэн татаж байвал юуны түрүүнд нэмэлт асуултуудыг асууж үзээрэй. Таны асуултад хариулж буй ажилтны нүүр болон биеийн хэлэмжийг анхааралтай ажиглаж үнэн ярьж байгаа эсэхийг тодорхойлох боломжтой. Таны хүссэн мэдээлэлд хариулт өгөхөөс татгалзах, зайлсхийх шалтгаан байхгүй.

Эмх цэгцгүй, утгагүй, ойлгомжгүй хариулт өгөх, эсхүл хариулахаас зайлсхийж мэдэн будлих, уурлах, маргалдах зэрэг түрэмгий үйлдэл илэрвэл та болгоомжлох хэрэгтэй.

7. Ямар ч тохиолдолд гэрээнд гарын үсэг зурах, хөрөнгө оруулахыг яаруулсан хатгалгад бүү ороорой.

Хэрэв борлуулалтын ажилтан таныг ямар нэг зүйлд нэн яаралтай гарын үсэг зурах шаардлагатай гэж шахааж байвал тэр нь мэргэжлийн арга барилыг баримтлахгүй байна гэсэн үг. Гэр бүлийнхэн болон хэн нэгэнтэй ярилцаж, хэлэлцэх хугацаа өгөхгүй бол шийдвэр гаргахаасаа өмнө дахин нягтлах шаардлагатай. Хэрэв үнэхээр бодит, ашигтай зүйл бол 24 цагийн дараа ч мөн боломжтой хэвээр байдаг.

Санхүүгийн луйврыг илрүүлэх болон хууль эрх зүйн орчин:

Санхүүгийн луйвар нь дараах шалтгааны улмаас илрүүлэхэд

хүндрэлтэй, хугацаа их шаардагддаг. Үүнд:

- Багаас эхлээд томордог, тиймээс эхний шатанд илрүүлэхэд хүндрэлтэй.
- Хувийн данс шалгах боломжгүй.
- Ёс зүйгүй санхүүгийн ажилтан, менежерүүд хуурамч тайлан гаргаж илгээдэг.
- Иргэдээс гомдол санал ирэх хүртэл мэдэх боломжгүй.
- Ашиг сонирхлыг урьдчилан мэдэх боломжгүй.
- Байнга хувьсаж өөрчлөгдөж байдаг тул хянахад хэцүү зэрэг багтана.

Иймээс олон улсад ашиглан, мөнгөний залилан, эрх мэдлээ хэтрүүлэн ашиглаж зүй бус шийдвэр гаргасан, эрх бүхий этгээдүүдтэй хамтран мөнгө угаасан, санаатайгаар хуурамч тайлан гаргасан зэрэг гэмт хэргүүдийг шалгадаг хүмүүс нь тусгайлан мэргэшсэн мөрдөн шалгах аудиторуд байдаг.

АНУ-аар жишээлбэл понзи луйврыг сэжиглэж байгаа тохиолдолд хууль ёсны арга хэмжээг дараах агентлаг, албан байгууллагууд хянан шалгадаг байна. Үүнд:

- Хэрэглэгчийн залилангийн хэргийг Холбооны худалдааны хороо (FTC)
- Үнэт цаасны луйврыг Үнэт цаас, биржийн хороо (SEC)
- “Онц ноцтой” санхүүгийн гэмт хэргийг мөрдөн байцаах ажиллагааг зохицуулах үүрэгтэй АНУ-ын 94 өмгөөлөгчийн газар, мөн 20 холбооны агентлагийг багтаасан Санхүүгийн залилангийн ажлын хэсэг
- Татварын залилангийн гэмт хэрэг үйлдсэн тохиолдолд Дотоод орлогын алба
- Луйврын хэргийг АНУ-ын өмгөөлөгч болон орон нутгийн прокуроруд мөрдөн байцаалт явуулдаг.

Хангалттай хэмжээний хяналт зохицуулалтын байгууллага ажилладаг боловч понзи луйвар буурахгүй байгаа бөгөөд 2019 онд хөрөнгө оруулалтын хэмжээгээр 3.2 тэрбум долларын хөрөнгө оруулсан 60 понзи схемийг илрүүлсэн байна. Бусдыг элсүүлэх эрх олж авахын тулд тодорхой хэмжээний хөрөнгө оруулалт шаардах, бусдыг элсүүлсний төлөө мөнгө өгөх бизнесийг хууль бус пирамид схемийн луйварт тооцон АНУ, Англи, Франц, Герман, Канад, Колумб, Малайз, Польш, Норвеги, Болгар, Австрали, Шинэ Зеланд, Япон, Итали, Непал, Исланд, Филиппин, Өмнөд Африк, ШриЛанк, Тайланд, Иран, Хятад, Мексик, Португал, Голланд зэрэг олон орон Хэрэглэгчийг хамгаалах хуулиар хориглосон. Хууль зөрчигчдөд хүлээлгэх хариуцлага нь ч өндөр байдаг байна. Тухайлбал, АНУ-д пирамид тогтолцоог үүсгэн байгуулсан, гүйцэтгэхэд нь тусалсан хүнийг арван мянган ам.доллараар торгох, албадлагын хөдөлмөр хийлгэх, эсвэл арван жил хорих ялаар шийтгэх хуулийн заалттай.

Манай улсад мөн пирамид тогтолцооны замаар ашиг олохыг хуулиар хориглосон. Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуульд зааснаар олон шатлалт маркетинг буюу пирамид тогтолцооны замаар хууран мэхэлж ашиг хонжоо олох үйл ажиллагааг хориглодог. Хүн ам цөөнтэй, жижиг эдийн засагтай гэж эдийн засагчид онцолдог хэдий ч Монгол Улсын нутаг дэвсгэрт 1970-аад оноос хойш пирамид болон понзи схемийн олон луйвар гарсан баримт бий. Их хэмжээний мөнгө цуглуулдаг сүлжээний бизнесүүдийг цагдаагийн байгууллага шалгаснаас ихэнх нь зохион байгуулалттай эдийн засгийн гэмт хэрэг

буюу залилангаар шийдэгдэж байсан байна.

Санхүүгийн луйврыг Монгол Улсын Эрүүгийн хуулийн 17.3 дугаар зүйлд зааснаар зохицуулдаг. Үүнд:

1. Хуурч, эсхүл баримт бичиг, эд зүйл, цахим хэрэгсэл ашиглаж, эсхүл зохиомол байдлыг зориудаар бий болгох, сүсэг бишрэлийг далимдуулах, бодит байдлыг нуух замаар бусдыг төөрөгдөлд оруулж, эсхүл нэр хүнд, урьдын харилцааны явцад бий болсон итгэлийг урвуулан ашиглаж эзэмшигч, өмчлөгчийн эд хөрөнгө, эд хөрөнгийн эрхийг шилжүүлэн авсан бол дөрвөн зуун тавин нэгжээс арван дөрвөн мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл хоёр зуун дөчин цагаас долоон зуун хорин цаг хүртэл хугацаагаар нийтэд тустай ажил хийлгэх, эсхүл зургаан сараас гурван жил хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах, эсхүл зургаан сараас гурван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

2. Энэ гэмт хэргийг:

2.1. албан тушаалын байдлаа ашиглаж;

2.2. бусдад ноцтой, эсхүл их хэмжээний хохирол учруулж үйлдсэн бол арван мянган нэгжээс дөчин мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл хоёр жилээс найман жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

3. Энэ гэмт хэргийг:

3.1. байнга үйлдэж амьдралын эх үүсвэр болгосон;

3.2. олон шатлалт маркетинг, пирамид тогтолцооны луйврын аргаар үйлдсэн;

3.3. зохион байгуулалттай гэмт бүлэг үйлдсэн бол таван жилээс арван хоёр жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

Яагаад санхүүгийн пирамид болон понзи схемийн луйврын хохирогчид буурахгүй байна вэ? ХЭРХЭН таслан зогсоох вэ?

Дэлхий даяар санхүүгийн пирамид болон понзи схемийн луйвар 100 жилийн турш оршин тогтнож, цаг хугацааны явцад арга хэрэгсэл нь хувьсан өөрчлөгдөж улам нарийссаар байгаа бөгөөд интернет бий болсноор үндэстэн, тив дамнасан шинжтэй болон өргөжин тэлсээр байна. Хүмүүсийн санхүүгийн мэдлэг дутмаг байдал, их мөнгийг хурдан хугацаанд олох хүсэл дээр үе үеийн гэмт хэрэгтнүүд тоглосоор ирсэн. Эдийн засагчдын үзэж байгаагаар санхүүгийн луйвар нь өөрөө томрох тусам хохирогчдын тоо нэмэгдэж, цөөхөн хэдэн хүнд ашигтай болдог ба санхүүгийн пирамид болон понзи схемийн луйвар нь байнга хувьсан өөрчлөгдөж, үйл ажиллагаагаа өнгөлөн далдалж багаас эхлэн аажим томордог тул илрүүлэхэд хүндрэлтэй, ихээхэн цаг хугацаа шаардагддаг. Дээрх луйврын системүүд эцэстээ нуран унаж, хууль, хяналтын байгууллагаас илрүүлж шийдвэр гарахад маш олон иргэд хөрөнгө, мөнгөөр хохирсон байдаг. Манай улсад залилан, сүлжээний луйврын гэмт хэрэгт хүлээлгэх хариуцлага, хууль эрх зүйн зохицуулалт байгаа боловч энэ төрлийн залилангийн хэрэг жил ирэх тусам нэмэгдэж, хохирогчдын тоо болон мөнгөн дүн өсөж байгааг хуулийн байгууллагын албан ёсны мэдээллээс харж болно. Иймд эрх бүхий байгууллагууд санхүүгийн луйврын талаар судалгааг өргөн хүрээтэй хийж, иргэдэд таниулж ойлгуулах, соён гэгээрүүлэх үйл ажиллагаа явуулах, хяналт шалгалтыг сайжруулах зэрэг арга хэмжээг авах шаардлагатай бөгөөд нөгөө талаас иргэд санхүүгийн мэдлэг боловсролоо дээшлүүлж, богино хугацаанд өндөр хүү, ашиг амласан санхүүгийн луйварт итгэж хөрөнгө оруулалт хийхгүй байх, тусгай зөвшөөрөлтэй, эрх бүхий байгууллагад бүртгэгдсэн хөрөнгө оруулалтуудыг сонгох хэрэгтэй. Ингэснээр өөрийгөө болон бусдыг санхүүгийн луйврын хохирогч болохоос сэргийлэх боломжтой юм.

КОМПАНИЙН ЗАСАГЛАЛ

ТУЗ–ИЙН 2021 ОНД АНХААРАХ АСУУДЛУУД

КОВИД–19: Цар тахал нь бизнес, нийгэм, эдийн засагт олон талаар нөлөөлсөн бөгөөд корона вирусийн халдварын хамгийн сүүлийн давлагааг даван туулж, вакцины үр дүн гарах хүртэл энэхүү тодорхойгүй байдал үргэлжлэх төлөвтэй. Энэ цаг үед засаглалтай холбоотой нөхцөл байдал бий болсон нь хямралын дараа ч хэвээр байх бололтой.

Нэгдүгээрт, ТУЗ нь компанийн бизнесийн уян хатан байдал буюу ирээдүйд үүсэж болох эрсдэлд бэлтгэхэд илүү их анхаарал хандуулах шаардлага үүсэв. Энэ нь эргээд эрсдэлийн удирдлагад үндэслэсэн суурь таамаглалуудыг туршиж, бизнест тулгарч буй эрсдэл ба боломжийн талаар цогцоор нь эргэцүүлэхэд хүргэсэн. Жишээлбэл, олон компаниудын хувьд цар тахал нь тэдний хангалт, нийлүүлэлтийн сүлжээний сул тал болон гол анхаарах асуудлууд нь ил болсон байна.

Түүнчлэн, цар тахлын үед олон нийтийн анхаарал нийгэм, эдийн засгийн тэгш байдлыг хангагдахад чиглэгдэж, үүнд компаниудын үүрэг оролцоо ихээхэн үүрэгтэй болсон. Ялангуяа ажилтнуудын эрүүл мэнд, ажлын байрны аюулгүй байдал нь бизнесийн гүйцэтгэлд төдийгүй компанийн нэр хүнд, байгууллагын соёл, хөрөнгө оруулагчдын хүлээлт зэрэгт сайн үр дагавар авчрах хандлагатай нэн тэргүүний зорилт болоод байна.

Цар тахлын үеэр мэдэгдэхүйц өөрчлөгдсөн өөр нэг зүйл бол компанийн харилцаа холбоо болон мэдээллийн ил тод байдал юм. Компанийн ажиллагсад, хөрөнгө оруулагчид, зохицуулагч байгууллагууд болон бусад оролцогч талуудын зүгээс мэдээллийн ил тод байдлыг дээшлүүлэхээр гаргаж байсан уриалгын дагуу олон компани энэ жил үүнд нэлээдгүй цаг хугацаа, анхаарал хандуулсан.

Цаашид ч оролцогч талууд Байгаль орчин, нийгэм ба засаглал (ESG)–ын эргэн тойронд харилцаа, мэдээллийн ил тод байдлыг илүү ихээр шаардах хандлагатай байна.

Олон талт байдал ба арьс өнгөний тэгш үзэл: КОВИД–19 цар тахал нь арьс өнгөөр ялгаварлан гадуурхах үзэлд шинэ хандлагыг авчрав. Apple, PayPal, LEGO, HP, Verizon, Uber, Bank of America, Visa зэрэг олон томоохон корпорациуд арьс өнгөний тэгш байдлыг санхүүгийн болон бусад чиглэлээр дэмжих үйл ажиллагаа явуулахаа мэдэгдсэн. Мөн Дэлхийн эдийн засгийн форум зэрэг байгууллагаас компаниудыг тэгш эрх, хүртээмж, шударга ёс зэргийг цогцлоохыг уриалж байна.

Мэргэжлийн хөрөнгө оруулагчдаас ч арьс өнгөөр ялгаварлан гадуурхах үзлийн эсрэг анхаарч эхэллээ. Тодруулбал, өнгөрсөн зун хөрөнгө оруулалтын State Street Corporation өөрийн хөрөнгө оруулалтын багцад багтах компаниудаасаа ТУЗ–ийн гишүүдийн арьс өнгө, үндэс угсаа зэрэг төрөлжилттэй холбоотой эрсдэл, зорилго, стратегия илэрхийлэх, мөн Нью–Йорк хотын 150.0 тэрбум ам.долларын хөрөнгө бүхий тэтгэврийн сангуудаас S&P 100 компаниудыг ажиллагсдынхаа мэдээллийг арьс өнгө, үндэс угсаа, хүйс зэргээр нь нийтэд ил болгохыг хүсчээ.

Томоохон корпорациудын хувьд ТУЗ–ийн бүрэлдэхүүний арьс өнгө, үндэс угсааны төрөлжсөн олон талт байдлыг нэмэгдүүлэх дүрэм,

журмыг зохицуулагчид баталж эхлээд байна. 2021 онд ISS (Institutional Shareholder Services)–ээс Russell 3000, эсхүл S&P 1500 индекс багтдаг ТУЗ–ийн “арьсны өнгө, эсвэл үндэс угсааны төрөлжилт”–гүй компаниудыг судалгааны тайландаа онцолсон бөгөөд 2022 оноос эхлэн нөхцөл байдал сайжрахгүй тохиолдолд эдгээр компаниудын нэр дэвшүүлэх ТУЗ–ийн гишүүдийн эсрэг санал өгөх шинэ бодлогыг гаргах аж. NASDAQ мөн бүртгэлийн шинэ дүрмийг санал болгож байгаа нь компаниудаас ТУЗ–ийн бүрэлдэхүүний төрөлжилтийн талаарх статистик мэдээллийг тогтмол мэдээлэх, мөн компаниудаас дор хаяж нэг эмэгтэй ТУЗ–ийн гишүүнтэй байх жишгийг шаардаж байна.

Нийгэм, эдийн засгийн тэгш бус байдал: АНУ–д эдийн засгийн тэгш бус байдал сүүлийн 50 жилд дээд түвшиндээ хүрчээ. 1989–2016 онуудад тус улсын хамгийн баян, ядуу гэр бүлүүдийн хоорондох хөрөнгийн ялгаа 2 дахин нэмэгдэж, америкчуудын дийлэнх хэсгийг бүрдүүлдэг байсан дундаж давхарга улам бүр багассан байна.

Америкчуудын 70 хувь нь манай эдийн засгийн тогтолцоо баячуудыг шударга бусаар дэмжиж, орлого ба баялгийн ялгааг улам ихэсгэж байгаад том корпорациудыг буруутгадаг гэхэд гайхах зүйлгүй.

КОВИД–19 хямралд эдийн засгийн эмзэг бүлгийн иргэд хамгийн ихээр нэрвэгдсэн ба баян хоосны ялгааг улам бүр нэмэгдүүлэв. Жишээлбэл, McKinsey & Company цар тахлын эдийн засгийн ойрын хугацааны нөлөөллийн 86% нь жилийн 40.0 мянган ам. доллараас бага цалинтай ажиллагсдад учирсан гэж тооцоолжээ.

Нийгэм, эдийн засгийн тэгш бус байдал нь сүрдмээр, төвөгтэй, системийн тулгамдсан асуудал боловч том корпорациуд нь өргөн цар хүрээнд ажил эрхлэх боломж, хөгжил цэцэглэлтийн хөдөлгөөр болдог. Иймд ажиллагсдынхаа сайн сайхан аж төрөх байдлын ач холбогдлыг бизнесийнхээ тогтвортой байдалтай уялдуулан ойлгож, олон нийттэй симбиоз харилцааг хөгжүүлэх замаар энэхүү тэгш бус байдлыг бууруулах боломжтой.

Үргэлжлэл бий...

Эх сурвалж: Harvard Law School Forum on Corporate Governance


ОЛОН УЛСЫН ЗАХ ЗЭЭЛИЙН МЭДЭЭ

ИХ БРИТАНИ УЛСЫН КОВИДЫН ӨРТӨГ НЬ ЗАСГИЙН ГАЗРЫН ЗАРДЛЫГ ДЭЛХИЙН 2-Р ДАЙНААС ХОЙШИХ ХАМГИЙН ӨНДӨР ТҮВШИНД ХҮРГЭСЭН

Их Британи Улсын Засгийн газрын зээл буюу зардал орлогын зөрүү нь 2021 оны 3 дугаар сард 303.1 тэрбум фунт стерлинг болсон гэж Үндэсний статистикийн газраас нь мэдээлэв. Энэ нь өмнөх онтой харьцуулахад 250 орчим тэрбум фунт стерлингээр илүү үзүүлэлт юм. Ажлаас түр зур чөлөөлөх зэрэг арга хэмжээ нь Засгийн газрын санхүүжилтэд хүндээр нөлөөлж байна. Зөвхөн 3 дугаар сарын зээлийн дүн 28 тэрбум фунт стерлинг хүрсэн нь өмнөх онуудад байгаагүй дээд хэмжээ болжээ.

Зураг 1. Төрийн салбарын цэвэр зээл

Жич: Төрийн банкуудыг оруулаагүй болно.




Эх сурвалж: Их Британийн Үндэсний статистикийн газар

Энэ жилээс өнгөрсөн жилийн хоорондох зээлийн 250 тэрбум фунт стерлингийн зөрүүгээс 200 гаруй тэрбум фунт стерлинг нь нэмэлт зарлага байгаа бол үлдсэн хэсэг нь татварыг бууруулахтай холбоотой гаргасан зардал юм. 2021 оны 3 дугаар сард НӨАТ, шатахууны татвар, бизнесийн татварын хэмжээ өнгөрсөн оны мөн үеийнхээс буурсан бол сайн дурын даатгал, цалингийн татвар, тэмдэгтийн хураамж, хөрөнгө орлогын албан татвар зэрэг нэмэгдсэн байна.

Ажлын байрны дэмжлэг намар хүртэл үргэлжилж байгаа бөгөөд татварын их хэмжээний хөнгөлөлт нь компаниудыг үйлдвэр, тоног төхөөрөмжид хөрөнгө оруулах боломжийг үүсгэж байгаа юм. Цар тахлын үеэр иргэд, аж ахуйн нэгжүүдийг дэмжих арга хэмжээнүүд 2021 оны 3 дугаар сар хүртэлх 1 жилийн хугацаанд Засгийн газрын өдөр тутмын зардлыг 203.2 тэрбум фунт стерлинг буюу 27.5 хувиар өсгөхөд нөлөөлсөн гэж Их Британийн Үндэсний статистикийн газраас мэдээлэв. Үүний зэрэгцээ татварын болон үндэсний даатгалын орлого 34.9 тэрбум фунт стерлингээр буюу өмнөх оны 12 дугаар сартай харьцуулахад 5 хувиар буурчээ.

Зураг 2. Засгийн газар дэлхийн хоёрдугаар дайнаас хойших авсан хамгийн өндөр зээл

/Улсын зээлийг ДНБ-д эзлэх хувиар/



Эх сурвалж: Их Британийн Үндэсний статистикийн газар

Их Британийн Үндэсний статистикийн газраас улсын нийт зээлийн ДНБ-д эзлэх хувь буюу үндэсний үйлдвэрлэлийн хэмжээ 14.5 хувь болж өссөн нь дэлхийн хоёрдугаар дайн дууссанаас хойш 1946 онд 15.2 хувь хүрснээс хойших хамгийн өндөр үзүүлэлт гэж мэдэгдэв. Өнгөрсөн 1 жилийн хугацаанд асар их хэмжээний зээл авсан нь улсын төсвийн өрийг 2.1 их наяд фунт стерлингт хүргэсэн нь ДНБ-ий 97.7 хувийг эзэлж байгаа нь 1960-аад оны эхэн үеэс хойш ажиглагдаж байгаагүй хэмжээ юм.

2021 оны 3 дугаар сард хөл хориог зөөлрүүлсэн явдал нь Их Британийн бизнес эрхлэгчдийн дунд идэвхжил нэмэгдсэн гэж үзэж байгаа тул эдийн засагт хурдан сэргэлт болно гэсэн найдвартай байна.


Ковидын тахал эхэлснээс хойш үйлчилгээний салбар анх удаа үйлдвэрлэлээс илүү хурдтай өссөн нь 2021 оны 4 дүгээр сарын дунд үеэс Англи, Уэльст зайлшгүй шаардлагатай дэлгүүрүүд нээгдсэнтэй холбоотой юм. Вирусийн хязгаарлалтыг цаашид сулруулж байгаа тул бизнесийн үйл ажиллагаа 2021 оны 5 болон 6 дугаар саруудад эрчимтэй өсөж эдийн засгийн хувьд хоёр дахь улирлын өсөлтийг эхлүүлэх ёстой.

ОЛОН УЛСЫН ХӨРӨНГИЙН ЗАХ ЗЭЭЛИЙН ИНДЕКС

2021 оны 04 дүгээр сарын 30-ны өдөр

S&P 500 /^GSPC/


4,211.47 +28.29 (+0.68%)



Эх сурвалж: www.finance.yahoo.com

Nikkei 225 /^N225/


28,812.63 -241.34 (-0.83%)



Эх сурвалж: www.finance.yahoo.com

FTSE 100 /^FTSE/


6,966.00 -4.39 (-0.06%)




Эх сурвалж: www.finance.yahoo.com

NASDAQ Composite (^IXIC)

14,082.55 +31.52 (+0.22%)




Эх сурвалж: www.Bloomberg.com

 Засгийн газрын IV байр, Бага тойруу-3 Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот, Монгол Улс 15160

 +976-51-264444

 press@frc.mn

 www.frc.mn

 Санхүүгийн зохицуулах хороо

 @FRC_of_Mongolia